

“МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН УДИРДЛАГА

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Төлөөлөгчдөд зориулсан гарын авлага

(Эхний хувилбар)

МОДУЛЬ 1: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН УДИРДЛАГА

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	ii
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	ii
НЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН АНГИЛАЛ.....	1
1.1. Орон нутгийн эдийн засаг, санхүүгийн үндэс.....	1
1.2. Орон нутгийн төсөв, түүний эрх зүйн зохицуулалт	1
1.3. Орон нутгийн төсвийн харилцааг зохицуулж буй хуулиуд.....	2
1.4. Монгол улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн	4
1.5. Улсын болон орон нутгийн төсвийн харилцаа.....	5
1.6. Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлага	6
ХОЁР. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ	15
2.1. Орон нутгийн төсвийн үйл ажиллагааны мөчлөг	15
2.2. Орон нутгийн төсвийг боловсруулж, бэлтгэх (төлөвлөх) үе шат.....	15
2.3. ИТХ-аар орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах үе шат	17
2.4. Орон нутгийн төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг зохион байгуулах үе шат	25
2.5. Орон нутгийн төсвийг хянаж, үнэлэх үе шат	34
ГУРАВ. УЛС, САЛБАР, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ БА ТӨСВИЙН УЯЛДАА.....	37
3.1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн тухай ойлголт	37
3.2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тавигдах шаардлага, цаглабар	39
3.3. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний цаглабар.....	40
ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ШИЙДВЭР ГАРГАЛТ, ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ.....	42
4.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвлөлт.....	42
4.2. Орон нутгийн хөгжлийн сан, түүний төлөвлөлт, шийдвэр гаргалт, хэрэгжилт, хяналт	44
4.3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн удирдлага, хяналт.....	54
ТАВ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ, ӨМЧИЙН УДИРДЛАГАД ИТХ, ТҮҮНИЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА.....	56
5.1. Орон нутгийн төсвийн талаарх ИТХ, Засаг даргын бүрэн эрх.....	56
5.2. Орон нутгийн төсвийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, зардлын мэдээллийг шинжлэх нь	56
5.3. Орон нутгийн төсөвт ИТХ-аас тавих хяналт.....	59
5.4. Орон нутгийн өмчийн талаарх ИТХ-ын эрх хэмжээ	64
5.5. Орон нутгийн төсөв, өмчийн удирдлага дахь ИТХ-ын Төлөөлөгчийн хүлээх хариуцлага - Ашиг сонирхлоос ангид байх	66
ДЭЛГЭРҮҮЛЖ СУДЛАХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	68

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсвийн захирагчид	4
Зураг 2. Монгол улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн	5
Зураг 3. Төсвийн хяналтын хэлбэрүүд	35

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Аймаг, сумын төсвийн татварын орлого	8
Хүснэгт 2. Аймаг, нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг	10
Хүснэгт 3. Сум, дүүргийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг	11
Хүснэгт 4. Байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах хөрөнгийн доод хэмжээ	13
Хүснэгт 6. Орон нутгийн төсвийн саналыг боловсруулж, хүргүүлэх цаглабар	16
Хүснэгт 7. Орон нутгийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах цаглабар	18
Хүснэгт 8. Аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн төсвийн төслийн бүтэц, агуулга	21
Хүснэгт 9. Орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг ил болгох цаглабар	31
Хүснэгт 10. Дотоод хяналт ба дотоод аудитын ялгаа	36
Хүснэгт 11. Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах цаглабар	39
Хүснэгт 12. ОНХС-ийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актууд	44
Хүснэгт 13. Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг ил тод болгох цаглабар	53
Хүснэгт 14. ОНХС-ийн зарим мэдээллийг хүйсээр ангилсан байдал	59

НЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН АНГИЛАЛ

1.1. Орон нутгийн эдийн засаг, санхүүгийн үндэс

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулинд нутгийн удирдлагын шинэ тогтолцооны гол хандлага нь өөрөө удирдах ёс болохыг томъёолсон. Ийнхүү орон нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогыг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана”, 58 дугаар зүйлд “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж заасан байдаг.

2019 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 59.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” гэж тусгасан.

Нутгийн удирдлагын зүгээс эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэйгээр чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн оролцоогүйгээр арвижуулан ашиглаж буй өмчийн зүйлс болох эд хөрөнгө, мөнгө санхүү, хуулиар баталгаажуулсан эд хөрөнгийн эрх зэргийг орон нутгийн эдийн засгийн үндэс гэж үздэг.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 5.1 дэх заалтад “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс нь түүнд хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, түүний хэвлий, байгалийн нөөц баялаг, орон нутгийн өмч, бүх төрлийн өмчийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос бий болсон хуримтлал, албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ”. Түүнчлэн засаг захиргааны санхүүгийн үндсийн талаар “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв” гэсэн 6-р зүйлд “Аймаг, нийслэл, сум, дүүрэг төсөвтэй байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэж хуульчилсан байна.

1.2. Орон нутгийн төсөв, түүний эрх зүйн зохицуулалт

Төсвийн тухай ойлголт

Төсөв гэдэг бол төлөвлөгөө юм. Тухайн жилд байгаа хөрөнгийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалт хийх чиглэлийг заасан санхүүгийн санал хэмээн ойлгож болно. Улсын төсвөөс олгох шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг хэлбэрээр хуваарилах хөрөнгө, орон нутгийн татварын болон татварын бус орлогын тооцоо бол энэ төлөвлөгөөний орлогын тал юм. Үйлчилгээ үзүүлэхэд болон хөрөнгө оруулалтад зарцуулж байгаа цалин, бараа материал, тоног төхөөрөмж зэрэг нь төсвийн зарлагын тал болно. Жилийн төлөвлөгөөнд орлого, зарлага тэнцсэн байх шаардлагатай бөгөөд үүнийг төсвийн тэнцэл гэж нэрлэдэг.

Төсөв яагаад шаардлагатай вэ?

Улсын төсвөөс санхүүжиж байгаа бүх байгууллага жилийн төсвөө боловсруулж батлуулах үүргийг хуулиар хүлээхийн зэрэгцээ улсын төсвийн хөрөнгөөр иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг хүргэх, хөрөнгө оруулалт хийх үүрэгтэй байдаг. Гэвч бүх иргэдийн хэрэгцээг хангахуйц хэмжээний орлого ямагт хүрэлцээтэйгээр бүрддэггүй учраас сонголт хийх шаардлагатай болдог. Төсвийн үйл ажиллагаа нь сонгуульт албан тушаалтнууд буюу ИТХ-ын Төлөөлөгчид иргэд, татвар төлөгчид, бусад сонирхогч талуудын саналыг сонссоны үндсэн дээр харилцан буулт хийх, зөвшилцөх замаар тэргүүлэх чиглэлийг тогтоох, засгийн газар, нутгийн удирдлага хөрөнгө мөнгийг хаана, юунд зарцуулах шийдвэр гаргах механизмыг бүрдүүлдэг.

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 4.1.5-д “төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг төсөв” хэмээн тодорхойлжээ.

1.3.Орон нутгийн төсвийн харилцааг зохицуулж буй хуулиуд

Төсөвтэй холбоотой харилцааг дараах хуулиуд, тэдгээрийг дагаж гарсан журмуудаар зохицуулж байна. Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал (Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 445-р тогтоол)
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам (Сангийн сайдын 2019 оны 282-р тушаал)
- Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам (Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29-р тогтоол)
- Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам (Сангийн сайдын 2012 оны 244-р тушаал)
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам (Сангийн сайдын 2018 оны 228-р тушаал)
- Сум хөгжүүлэх санг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам (Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153-р тогтоол)

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар Монгол Улсын нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн харилцааг зохицуулдаг. Тухайлбал, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсвэл ашигтай байх шаардлагатай. Мөн нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох, тухайн жилийн нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн хувь болон улсын өрийн хязгаарыг хуульчилж өгсөн байдаг.

Төсвийн тухай Монгол Улсын хуулиар (2011 оны 12-р сарын 23-нд батлагдсан) төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Энэхүү хуулийн “Орон нутгийн төсвийн харилцаа” гэсэн есдүгээр бүлэг нь төсвийн шатлал хоорондын харилцаа, орон нутгийн төсвөөр

аймаг, нийслэл, сум, дүүргийн хэрэгжүүлэх чиг үүрэг, орон нутгийн хөгжлийн сан, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, орон нутгийн хэрэгцээнд зориулж өр үүсгэх, орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах, ИТХ, Засаг даргын төсвийн удирдлага, санхүүжилтийн талаарх бүрэн эрх, орон нутгийн төсвийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулахад чиглэдэг байна. Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх тайлагнахад төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх гэсэн үндсэн 5 зарчмыг баримтална.

Шилэн дансны тухай хууль 2014 оны 7-р сарын 1-нд батлагдаж, 2015 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж байна. Шилэн дансны тухай хуулийн зорилго нь төсвийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, төсвийн удирдлагад иргэдийн хяналтыг бий болгох явдал юм. Шилэн дансны хууль батлагдсантай холбогдуулан улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг олон нийтэд олгох үүднээс Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг боловсруулан ашиглаж байна. Шилэн дансны цахим хуудсанд төрийн байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал, эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээний мэдээллийг иргэдэд нээлттэйгээр харуулах боломж бүрдсэн. Иргэд <https://shilendans.gov.mn/> цахим хуудсаар дамжуулан эдгээр мэдээллийг авах боломжтой. Төрийн мөнгөнд хяналт тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр төсвийн үрэлгэн байдлыг арилгах боломж бүрддэг.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” шинэчлэгдэн батлагдсан. Шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлэх ба байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгохоор хуульчилсан байна.

Иргэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаарх өргөдөл, гомдлыг төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно. Төрийн аудитын байгууллага нь гомдол, мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тухайн иргэнд бичгээр болон олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Төсвийн зарчмууд

Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.

1. *Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх:* Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон төсвийн тэнцэл хангагдсан байх ба төсвийн орлого буурах, зарлага нэмэгдсэнээр алдагдал үүсэхээр бол төсөвт тодотгол хийж төсвийг тэнцвэржүүлэх, төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх
2. *Иж бүрэн байх, үнэн зөв байдлыг хангасан байх:* Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг нийт дүнгээр нь төлөвлөж тайлагнах, санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу үнэн зөв бүртгэж тайлагнах
3. *Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлсэн байх:* Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, тайлагнах, өр төлбөр үүсгэхгүй, төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх

4. *Ил тод байх*: Төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, иргэдийг мэдээлэл авах бололцоогоор хангаж мэдээллийг ойлгомжтой байдлаар мэдээлэх
5. *Хариуцлагатай байх*: Төсвийн захирагч нь хуулиар олгосон эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, төсвийн захиран зарцуулалтын талаар томилсон байгууллага болон дээд шатны төсөв захирагчийн өмнө хариуцлага хүлээх

Төсвийн захирагчид

Төсвийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтныг төсвийн захирагч гэх бөгөөд Төсвийн тухай хуулиар төсвийн захирагчдыг:

- Төсвийн ерөнхийлөн захирагч
- Төсвийн төвлөрүүлэн захирагч
- Төсвийн шууд захирагч гэж ангилдаг (Төсвийн тухай хууль, 2011).

Зураг 1. Төсвийн захирагчид

Төсвийн ерөнхийлөн захирагч	•Өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд (ТТХ, 4.1.36) •Жишээлбэл, ИТХ-ын дарга тухайн шатны ИТХ-ын төсвийн, Засаг дарга тухайн шатны орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч.
Төсвийн төвлөрүүлэн захирагч	•Төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд (ТТХ, 4.1.37) •Өөрөөр хэлбэл, төлөөлөн гүйцэтгэх гэрээний дагуу тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж буй байгууллагуудын хувьд Засаг дарга нар төвлөрүүлэн захирагч юм.
Төсвийн шууд захирагч	•Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд (ТТХ, 4.1.38) •Тухайн төсвийн байгууллагын дарга нар. Жишээлбэл, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч гэх мэт.


Эх сурвалж: Төсвийн тухай Монгол улсын хууль (шинэчилсэн найруулга)-д тулгуурлан зураглав.

Орон нутгийн төсвийн хувьд ИТХ-ын дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар төсвийн ерөнхийлөн захирагч болно. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд Төлөөлөн гүйцэтгэх гэрээгээр буюу тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга нар байна. Төсвийн шууд захирагч нь тухайн төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нар юм.

1.4.Монгол улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн

Төсвийг шатлалаар ангилан авч үзвэл Монгол улсын нэгдсэн төсөв нь Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв гэсэн 4 зэрэгцээ төсвөөс бүрдэнэ.

Зураг 2. Монгол улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн



Монгол улсын нэгдсэн төсвийн үндсэн бүрэлдэхүүн болох орон нутгийн төсвийг Төсвийн тухай хуулийн 4.1.27 дахь заалтад “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсөв” гэж тодорхойлсон байдаг. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэх бөгөөд сүүлийн жилүүдэд нэгдсэн төсвийн 30 орчим хувийг эзэлж байна.

Орон нутгийн төсөв

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлэх төсөвтэй байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг.

Төсвийн тухай хуулийн 4.1.27 дахь заалтад “Орон нутгийн төсөв” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Орон нутгийн төсөв нь Монгол улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн болох бөгөөд орон нутгийн төсөвтэй холбоотой харилцааг зөвхөн Төсвийн хуулиар зохицуулна. Түүнчлэн энэ хуульд орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн шатлал хоорондын харилцааны асуудлыг тусгаж өгсөн байдаг.

1.5. Улсын болон орон нутгийн төсвийн харилцаа

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжүүлж байгаа мөнгөний хувьд төв, орон нутгийн төсөв хоорондын харилцааны асуудал яригддаг байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 3 төрлийн шилжүүлэг олгодог. Үүнд:

- Орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулж олгох *санхүүгийн дэмжлэг*
- Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь зориулж орон нутгийн хөгжлийн санд олгох *орлогын шилжүүлэг*
- Засгийн газрын хэрэгжүүлэх зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд зориулж улсын төсвөөс олгох *тусгай зориулалтын шилжүүлэг* хамаарна.

Сум, дүүргийн төсвийн дээд шатны төсөв нь аймаг, нийслэлийн төсөв, харин аймаг, нийслэлийн төсвийн дээд шатны төсөв нь улсын төсөв юм.

УИХ-аар тухайн төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон

нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх зэргийг хуульчлан баталдаг.

Дээрх 3 төрлийн шилжүүлэг нь улсын төсөвт нийт дүнгээрээ батлагдан орон нутагт шилжих бөгөөд аймаг, нийслэл нь сум, дүүрэгт олгох шилжүүлгийг мөн нийт дүнгээр нь баталж хүргүүлдэг бол сум, дүүрэг нь тухайн шатны ИТХ-аараа зардлын зүйл, зориулалт, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрээр төсвийн төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлнэ. Тухайлбал, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагуудын төсвийг баталж, хэрэгжүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих эрхийг нь гэрээгээр орон нутагт бүрэн шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл, байгууллага Засаг даргаараа дамжуулан тухайн шатны ИТХ-аар төсвөө хэлэлцүүлэн батлуулж, Засаг дарга санхүүжилтийн хуваарийг баталж, батлагдсан хуваарьтаа журам зохицуулалтын дагуу өөрчлөлт оруулах замаар үйл ажиллагаагаа удирдан хэрэгжүүлэх боломжтой болсон.

Төсвийн хуулиар аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийг, сум, дүүргийн Засаг дарга сум, дүүргийнхээ жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлдэг. Ингэснээр улсын төсвөөс олгогдсон санхүүжилтийн дүндээ багтаан санхүүжилтийн хуваарьт зохицуулалт хийх замаар дансны үлдэгдлээ удирдах, хугацаа хэтэрсэн өр авлага үүсгэхгүйгээр төсвийн шийдвэр гаргах эрхтэй.

Төсвийн тухай хуульд 2016, 2017 онд нэмэлт өөрчлөлт орсноор доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт дараах байдлаар төвлөрүүлэх болсон юм.

56.2.1. Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн 60 хувийг 2017 оны төсвийн жилд, 40 хувийг 2018 оны төсвийн жилд, 60 хувийг 2019 оны төсвийн жилд, 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.

56.2.2. Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас их тохиолдолд суурь зарлагатай тэнцэх хэсгийн 60 хувийг 2017 оны төсвийн жилд, 40 хувийг 2018 оны төсвийн жилд, 60 хувийг 2019 оны төсвийн жилд, 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.

1.6. Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлага

Төсвийн тухай хуулийн дагуу “орон нутгийн төсвийн суурь орлого, суурь зарлага” гэдэг ойлголт бий болсон. Энэ нь доод шатны төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг тодорхойлоход ашиглагддаг. Жишээлбэл, улсын төсвийн хувьд аймгуудын суурь орлого, зарлагыг тооцсоны үндсэн дээр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээ хуваарилах бол аймаг, нийслэл нь сум, дүүргийн суурь орлого, зарлагыг тооцон санхүүгийн дэмжлэгийг тодорхойлдог.

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлдэг. Орон нутаг дээрх суурь орлогоо нэмэгдүүлэн нэмэлт орлого олох боломжтой болсон бөгөөд энэхүү нэмэлт орлогын дүнг оруулаагүй дүнгээс суурь төсвийн тэнцлийг дээд шатны төсөв нь тооцож, санхүүгийн дэмжлэгийг олгоно.

Орлогоо нэмэгдүүлж нэмэлт орлого олох боломжийг хуулиар олгосон. Тухайлбал, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь зарим төрлийн татвар, хураамжийн хувь хэмжээг Улсын Их Хурлаас баталсан дээд болон доод хязгаарын хүрээнд нэмэгдүүлэн батлах эрхтэй, ийнхүү батлахдаа сум бүрийн саналыг харгалзан ялгаатай тогтоож өгч болно. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, автотээврийн болон

өөрөө явагч хэрэгслийн албан татвар, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ зэргийг нэмэгдүүлж, нэмэлт орлого олж болно. Жишээлбэл, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувийг 0.6-1.0 хувийн хооронд тогтоохоор хуульчилжээ.

Орон нутгийн төсвийн суурь зарлага гэдэг нь төсвийн хуульд тусгагдсан орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зардлыг хэлнэ. Орон нутгийн төсвийн зарлага нь урсгал зардал, хөрөнгийн зардлаас бүрдэнэ.

Орон нутгийн орлого, зарлага тэнцсэн байх шаардлагатай, үүнийг *төсвийн тэнцэл* гэдэг. Төсвийн орлого нь зарлагаасаа их бол суурь тэнцэл ашигтай, харин ороого нь зарлагаасаа бага бол суурь тэнцэл алдагдалтай гэж үздэг. Тухайн шатны төсвийн суурь тэнцлийн алдагдлыг дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлдэг.

Орон нутгийн төсвийн орлого, түүний эх үүсвэрүүд

Төсвийн орлого гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх татварын болон татварын бус орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг хэлнэ. Төсвийн орлого нь татварын болон татварын бус орлогоос бүрдэх бөгөөд татварын орлого нь Татварын ерөнхий хуулиар тогтоосон албан татвар, төлбөр, хураамжаас, татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсан, түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламж, хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсвийн нийт орлого гэдгийг орон нутгийн төсвийн суурь орлого болон хуулиар тухайн шатны ИТХ-д олгосон эрх хэмжээний дагуу татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон орлогын нийлбэр гэж тодорхойлж болно.

Монгол улсад 13 албан татвар, 13 төлбөр, 3 хураамж, нийт 29 татвар бий (Татварын ерөнхий хууль (2019), 7.2 дахь заалт).

Татварын хувь, хэмжээг УИХ, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ хууль тогтоомжийн дагуу тогтооно. Тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд УИХ-аас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан *аймаг, нийслэлийн ИТХ дараах албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоож болно* (Татварын ерөнхий хуулийн 8.3 дахь заалт). Үүнд:

- Хувь хүний орлогын албан татвар;
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;
- Малын тоо толгойн албан татвар;
- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;
- Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;
- Нийслэл хотын албан татвар;
- Нохойны албан татвар;
- Байгалийн ургамал ашигласны төлбөр;
- Рашаан ашигласны төлбөр;
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь, хэмжээг УИХ-аас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан сум, дүүргийн ИТХ тогтоож болно (Татварын ерөнхий хуулийн 8.4 дэх заалт) гэж заасны дагуу “Хог хаягдлын тухай”

хуулиар энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх зардлын нэгж тарифыг сум, дүүргийн ИТХ баталж байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн татварын орлогыг дараах байдлаар ангилсан байна.

Хүснэгт 1. Орон нутгийн төсвийн татварын орлого

<i>Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого (23.6)</i>	<i>Сум, дүүргийн төсвийн татварын орлого (23.8)</i>
- Нийслэл хотын албан татвар - Газрын төлбөрийн 60 хувь - Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар - Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар - Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр - Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар - Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар - Энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж - Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20 хувь	- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар - Галт зэвсгийн албан татвар; - энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж - Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж - Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж - Байгалийн ургамал ашигласны төлбөр; ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр - Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр - Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр - Нохойны албан татвар - Хог хаягдлын үйлчилгээний хураамж - Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувь - Газрын төлбөрийн 40 хувь

Орон нутаг суурь орлогоо нэмэгдүүлэн нэмэлт орлого олох боломжтой бөгөөд энэхүү нэмэлт орлогын дүнг оруулаагүй дүнгээс суурь төсвийн тэнцлийг дээд шатны төсөв нь тооцож, санхүүгийн дэмжлэгийг олгоно.

Малын тоо толгойн татвар

Малын хөлийн татварыг 20-иод жилийн өмнөөс мал сүргийг хонин толгойд шилжүүлж, татвар авдаг байсан түүх бий. Тухайлбал, бод малыг таван хоньтой дүйцүүлж, 50-75 төгрөгийн татвар ногдуулдаг байсан байна. Малын хөлийн татвараас нэг суманд жилд 5-6 сая төгрөгийн орлого бүрдүүлдэг байжээ.

Монгол Улсын мал сүргийн тоо сүүлийн 30 жилд 45.1 сая толгойгоор нэмэгдэж, 70.9 саяд хүрсэн. Энэ нь хүн амын хүнсний хэрэглээ, малчдын амьжиргаа, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн боловч өсөн нэмэгдэж байгаа малын тоо толгой нь бэлчээрийн хүрэлцээ, усны хомсдол үүсгэх болжээ. Иймд орон нутгийн төсвийг нэмэх, бэлчээр ашиглалт, цөлжилт, худаг усны хангамж гэсэн тулгамдсан асуудлаа орон нутагт бие даан шийдвэрлэх боломж олгож, сум, дүүргийн ИТХ-д малын тоо толгойн албан татварыг хуульд заасан хязгаарт багтаан бие даан тогтоох эрхийг “Малын тоо толгойн албан татварын тухай” хуулиар олгож, 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөхөөр болж байна. Сум, дүүргийн ИТХ-д малын тоо толгойн албан татварыг хуульд заасан хязгаарт багтаан бие даан тогтоож ОНХС-даа хуримтлуулан зарцуулах эрхийг олгосноор орон нутгийн төсвийн эх үүсвэр нэмэгдэж, бэлчээр ашиглалт, цөлжилт, худаг усны хүрэлцээ, мал сүргийн, эрүүл мэндийг хамгаалах, сүргийн бүтэц зэрэг асуудлыг бие даан шийдвэрлэх боломж бүрдэж байна.

“Малын тоо толгойн татварын тухай” хуульд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна. Албан татвар төлөгчийн өмчилж буй малын тоо толгойд албан татвар ногдуулна. Албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлох ба гамшгийн улмаас хорогдсон бол нотлох баримтыг үндэслэн түүнийг албан татвар ногдуулах нийт малын тооноос хасаж тооцож болно.
- Нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байх бөгөөд энэхүү хязгаарт багтаан сум, дүүргийн ИТХ малын төрөл тус бүрээр татварын хэмжээг тогтооно. Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно. Татварыг 0 болгож хөнгөлөх малын тоо толгойн тоог сум, дүүргийн ИТХ малын төрөл тус бүрээр тогтоож болно.
- Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө гэж хуульчилсан байна.

Манай улсын 70.9 сая толгой малд 1000-2000 төгрөгийн татвар ногдуулахад 70-141 тэрбум төгрөг сумдын төсөвт төвлөрөх тооцоо гарсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага, түүний ангилал

“Төсвийн зарлага” гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг хэлдэг.

Орон нутгийн төсвийн суурь зарлагад аймаг, нийслэл, сум дүүргийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон урсгал болон хөрөнгийн зарлага, аймаг, нийслэлд нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах болон сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх зохион байгуулах, аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон сум, дүүргийн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардлууд орж байна.

Орон нутгийн төсвийн суурь зардал тооцох аргачлал (Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан) нь доод шатны төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг тодорхойлох, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээнд төсвийн хуваарилалтын тэгш зарчим баримталдаг байх зорилгоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоход мөрдөж байна.

Суурь орлого ба суурь зарлагыг доод шатны төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг тодорхойлоход ашигладаг. Жишээлбэл, улсын төсвийн хувьд аймгуудын суурь орлого, зарлагыг тооцсоны үндсэн дээр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээ хуваарилах бол аймаг, нийслэл нь сум, дүүргийн суурь орлого, зарлагыг тооцон санхүүгийн дэмжлэгийг тооцож тодорхойлдог.

Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг

Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг Төсвийн тухай хуульд аймаг, нийслэл, сум, дүүргээр зааглан тусгасан байдаг.

Хүснэгт 2. Аймаг, нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг

Нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг (58.1)	Аймгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг (58.2)
- Нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх - Хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох - Нийслэлийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх - Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх - Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх - Бэлчээрийн менежмент хийх - Усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх - Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх - Үерийн хамгаалалтыг зохион байгуулах - Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх - Мал амьтны халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх - Гамшгаас урьдчилан сэргийлэх - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх - Нийслэлийн доторх томоохон авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох - Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах - Нийслэлийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдсон бусад үйл ажиллагааг эрхлэх - Төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын байрлаж байгаа нийслэлийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт - Соёлын үйлчилгээ - Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	- Аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх - Хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох - Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх - Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх - Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх - Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх - Малын тэжээлийн нөөц бүрдүүлэх - Усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууц, нийтийн аж ахуй, үерийн хамгаалалтыг зохион байгуулах - Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх - Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх - Аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох - Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах - Аймгийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдсон бусад үйл ажиллагааг эрхлэх - Төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын байрлаж байгаа орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт - Соёлын үйлчилгээ - Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Төсвийн тухай хуульд сум, дүүргийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 3. Сум, дүүргийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг

Дүүргийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг (58.3)	Сумын төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг (58.3)
- Дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх; - Дүүргийн засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах; - Дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх; - Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх; - Дүүргийн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах; - Дүүргийн доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах; - Дүүргийн тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, арчлах; - Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	- Сумын удирдлагыг хэрэгжүүлэх; - Сумын засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах; - Сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх; - Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх; - Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх; - Сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах; - Сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах; - Сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арчлах; - Усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх; - Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх; - Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдгээр чиг үүргийг тухайн шатны төсөвт төвлөрч буй татварын болон татварын бус орлого, дээд шатны төсвөөс олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлдэг.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал

Орон нутгийн түвшинд Байгаль хамгаалах хуулийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь өөрийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төсвийг баталж, хяналт тавих үүрэг хүлээдэг.

Төсвийн тухай хуулиар улсын болон орон нутгийн төсвийн чиг үүргийг тусгайлан зааглаж, орон нутгийн ИТХ, Засаг дарга өөрийн нутаг дэвсгэрийн байгаль орчны санхүүжилтийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэхээр эрх мэдэл нь шилжсэн юм. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний менежментийн төлөвлөгөөг боловсруулан ИТХ-аараа батлуулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хууль (ТТХ)-аар нөхөн сэргээгдэх байгалийн нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр, Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-д орон нутгийн төсвийн суурь зарлагад байгаль орчныг хамгаалах, нөхөн

сэргээх чиг үүрэгтэй холбогдох урсгал зардлыг оруулж тооцохоор (МУЗГ, Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал, 1.2.4, 2019), байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх зориулалтаар зарцуулах хөрөнгийн хэмжээг Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасныг баримтлан орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр (МУЗГ, Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал, 5.3, 2019) тус тус зохицуулжээ.

Үүний дагуу аливаа байгалийн нөөц баялгийг ашигласны төлбөр, хураамжийн хэмжээг орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-аас хуулинд заасан хязгаарт багтаан тогтоож, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлдэг ч холбогдох хуулийн хүрээнд ИТХ-аас тогтоосон төлбөрийг тухайн шатны төсөвт бүрэн төвлөрүүлж, хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд бүрэн зарцуулахгүй, өөр зориулалтаар ашигласаар байна. Тухайлбал, байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлого нь төсвийн дутууг нөхөхөд зарцуулагддаг, төсвийн орлого талд төлөвлөдөг боловч зарлага талд нь буюу байгаль хамгаалах, баялгийн нөөцийг нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлыг төлөвлөж, зарцуулахгүй байна.

Байгалийн ургамал, ус, ой, ан амьтны нөөцийг ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар (2012), харин Газар болон түүний хэвлийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг Газрын төлбөрийн тухай (1997), Ашигт малтмалын тухай (2006) хуулиар тус тус зохицуулдаг. Харин байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж нь аль шатны ямар төсвийн орлого болохыг Татварын ерөнхий хууль болон Төсвийн тухай хуулиар зохицуулдаг бөгөөд ашигт малтмалаас бусад нөхөн сэргээгдэх байгалийн нөөцийн төлбөр орон нутгийн төсвийн орлогод ордог.

Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийн төлбөрийн тодорхой хувийг тухайн байгалийн баялгийг хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах үзэл баримтлал нь анх Монгол улсад 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийг хэрэгжүүлж эхэлснээр биеллээ олсон бөгөөд энэ хуулийн үзэл баримтлалыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн баталсан Байгалийн нөөц ашигласны төлбөр (БНАТ)-ийн тухай хуулинд тусгаж, уг хуулийг хүчингүй болгожээ.

БНАТ-ийн тухай хуулийн зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн ургамал, ус, ой, ан амьтны нөөцийг ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Төсвийн тухай хуулиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 5% (жилд 20 гаруй тэрбум төгрөг), газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь нь улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаар дамжин аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд дахин хуваарилагддаг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн тодорхой хувийг тухайн сумын байгаль хамгаалах арга хэмжээ болон бэлчээрийн менежментийг сайжруулахад зарцуулах боломжтой юм (Төсвийн тухай хууль, 60.3.1).

Нөхөн сэргээгдэх ба үл сэргээгдэх байгалийн баялаг нь хүн төрөлхтөнд шууд болон шууд бусаар үр ашгаа өгч байдаг үнэт зүйл юм. Зах зээлийн чөлөөт өрсөлдөөн дэх шударга бус байдал, авилга, хээл хахууль, хуулийн хэрэгжилт сул зэрэг олон шалтгаанаас уламжлан байгалийн баялгийн хэт ашиглалт, улмаар хомсдолыг үүсгэдэг. Иймд байгалийн баялгийн зүй зохистой ашиглалтыг бий болгох зорилгоор ихэнх орнууд байгалийн баялгийн төлбөрийг бий болгодог.

БНАТ-ийн тухай хуулиар байгалийн ургамал, ус, рашаан, ой, ан, амьтны нөөц ашигласны төлбөрөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ (БОХНСАХ)-нд зарцуулах хөрөнгийн доод хувь хэмжээг тогтоож, түүнээс илүү зарцуулах эрх мэдлийг тухайн шатны ИТХ тогтоодог байхаар зохицуулсан байна.

Хүснэгт 4. Байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах хөрөнгийн доод хэмжээ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	БОХНСАХ-нд зарцуулах доод хэмжээ (нийт орлогын дүнгээс хувиар)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь
Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
Газрын нөөцийн төлбөрийн орлого	15 хувь
Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь

Эх сурвалж: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012). 18.1 дэх заалт.

Орон нутагт байгаль орчны санхүүжилт дараах эх үүсвэрүүдээс бүрддэг. Үүнд:

- 1) Орон нутагт ажилладаг байгаль орчны салбарын байгууллагуудын Төсвийн тухай хуульд заасны дагуу баталсан төсөв
- 2) Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 23.8.4-23.8.9 дэх заалтын дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орох орлого
- 3) Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6.2-ын дагуу орон нутгийн төсөвт төлсөн нөөц ашигласны төлбөр хураамж
- 4) Сангийн сайдын 2014 оны 43 тоот ОНХС-гийн журамд заасан орон нутгийн хөгжлийн сангийн орлого зэрэг орлого хамаарна.

Аймаг, сумын түвшинд байгаль орчныг хамгаалахад төсөв зарцуулах шаардлага

Орон нутгийн ИТХ, Засаг дарга хуулиар ногдуулсан чиг үүргийг орон нутагтаа хэрэгжүүлэхдээ шаардагдах төсвийг 2012 онд батлагдсан “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс бүрдүүлж байна. Үүнд байгалийн ургамлын, ус, рашааны, ойн, ан амьтны, газрын нөөц ашигласны төлбөрийн орлогыг санхүүгийн эх үүсвэр болгон ашигладаг. Уг төлбөрийн орлогоор санхүүжүүлж, хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр ИТХ баталж, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн дагуу нөхөн сэргээгдэх байгалийн нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх, харин орон нутгийн төсвийн суурь зарлагад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиг үүрэгтэй холбогдох (Төсвийн тухай хуулийн 58.1.14; 58.2.13; 58.3.5; 58.4.6) урсгал зардлыг оруулан тооцож, санхүүжүүлэхээр зохицуулсан (Төсвийн тухай хууль 4.1.30) байдаг.

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1.2.4 дэх заалтад “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардал” гэж Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгө, аймгийн байгаль орчны газар, сум дундын ойн ангийн үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардлын нийлбэрийг хэлнэ гэж тусгажээ.

Аймаг, нийслэлийн байгаль хамгаалах газар, сум дундын ойн ангийн үйл ажиллагааны урсгал зардалтай холбогдох орон нутгийн байгаль хамгаалах ажилтны цалин хөлсийг Засгийн газраас хамгийн сүүлд баталсан төрийн албан хаагчийн цалин, нэмэгдлийн жишгээр; улирлын үр дүнгийн урамшууллыг Засгийн газрын тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журамд заасны дагуу; харин төрийн албан хаагчид олгох тэтгэмж, тусламжийг холбогдох эрх зүйн актад заасны дагуу; цалингаас тооцох нэмэгдэл, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн бусад актад заасан хувь хэмжээгээр тооцно.

Байгаль орчны байгууллага, ойн ангийн байрлаж байгаа байрны түлш, халаалтын зардал, цэвэр болон бохир ус, цахилгаан эрчим хүч, байрны түрээсийн төлбөр зэрэг байр ашиглалтын зардлыг тухайн барилга байгууламжийн эзлэхүүн, өмнөх жилийн зардлын суурь түвшинг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөгдөж байгаа үнэ тарифын өөрчлөлттэй харьцуулан тооцдог байна.

Байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн албан хаагчийн үйл ажиллагааны урсгал зардлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан ИТХ, Засаг даргын чиг үүргийг суурь түвшний төсөвтэй нь харьцуулж, дараах зүйлсийг харгалзан тогтоохоор журамлажээ. Үүнд:

- Байгалийн бүсчлэлд хамрагдсан сумд;
- Байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн норматив;
- Улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авч хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоох эсэх;
- Хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчныг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох эсэх;
- Байгаль орчны байцаагчийг нормын хувцас, ялгах тэмдэг, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах шаардлагатай эсэх;
- Харьяалах нутаг дэвсгэрийн байгалийн тогтоц, хэв шинж;
- Уул уурхайн олборлолт хийсний улмаас байгаль орчны үнэлгээ хийж байгалийг нөхөн сэргээх шаардлага гарсан эсэх;
- Байгалийн нөөцийг нөхөн сэргээх шаардлагатай эсэх.

Сум дундын ойн ангийн орон тооны дээд хязгаарыг Сангийн сайдын баталсан орон тооны жишиг, хязгаарын дагуу тогтоож, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны урсгал зардлыг холбогдох эрх зүйн актаар баталгаажсан чиг үүрэг, арга хэмжээг суурь түвшний төсөвтэй харьцуулан хянаж дараах зүйлсийг харгалзан тооцно. Үүнд:

- Засгийн газраас тогтоосон ойн ангийн хариуцах талбайн норматив;
- Харьяалах нутаг дэвсгэрийн байгалийн тогтоц, хэв шинж;
- Байгаль хамгаалагчийг нормын хувцас, ялгах тэмдэг, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах шаардлагатай эсэх;
- Байгалийн нөөцийг нөхөн сэргээх шаардлагатай эсэх;
- Ой цэвэрлэх, нөхөн сэргээх шаардлагатай эсэх зэрэг үзүүлэлт хамаарна.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зориулалтаар зарцуулах хөрөнгийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан орлогын төрөл, хувь хэмжээгээр тооцно.

ХОЁР. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ

2.1. Орон нутгийн төсвийн үйл ажиллагааны мөчлөг

Жилийн төсвийн төслийг бэлтгэх, өргөн барих, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх ажиллагааг нийтэд нь төсвийн мөчлөг гэдэг. Ерөнхийдөө төсвийн мөчлөг тухайн санхүүгийн жилээс нэг жилийн өмнө эхэлж, санхүүгийн жил дуустал үргэлжилдэг.

Орон нутгийн төсвийн мөчлөг нь:

- Орон нутгийн төсвийг боловсруулж, бэлтгэх;
- ИТХ-аар төсвийг хэлэлцэн батлах;
- Төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Төсвийг хянаж, үнэлэх үе шатуудаас бүрдэнэ.

Эдгээр шат тус бүрт ИТХ-ын зүгээс мэдвэл зохих, анхаарах асуудлуудыг авч үзье.

2.2. Орон нутгийн төсвийг боловсруулж, бэлтгэх (төлөвлөх) үе шат

Төсвийн тухай хуулийн “төсвийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах” гэсэн 5 дугаар бүлгийн 27-р зүйлд төсвийн төсөлд тавигдах шаардлага, 28-р зүйлд орон нутгийн төсвийг боловсруулж ИТХ-д өргөн барих цаглабарыг тогтоосон.

Орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, өргөн барих асуудлыг Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр 244 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-аар (журмыг хавсралтаас үзэж болно) зохицуулж байна. Уг журамд орон нутгийн төсвийн төсөл боловсруулахад баримтлах зарчим, төсвийн удирдамж, орон нутгийн суурь төсвийн санал боловсруулах, тусгай сангуудыг төлөвлөх, төсвийн тодотголын төсөл боловсруулах, төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах зэрэг асуудлыг тусгажээ.

Төсвийн тухай хуульд төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төсөл боловсруулах нарийвчилсан удирдамжийг Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ гэж заасны дагуу Сангийн яамнаас төсвийн удирдамжийг боловсруулж аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 05-ны дотор хүргүүлдэг.

Төсвийн удирдамжид төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн Засгийн газраас баталсан жилийн төсвийн хязгаар (нийслэл болон аймаг тус бүрээр тооцсон санхүүгийн дэмжлэгийн дээд хязгаар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын доод хэмжээ, орлогын шилжүүлгийн доод хэмжээ), улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн талаарх бодлогын чиглэл, Засгийн газраас ирэх жилд орон нутгийн хөгжлийг дэмжихэд баримтлах бодлого, чиглэл болон нийслэл, аймгуудын төсвийн төсөл боловсруулж ирүүлэх хугацааг заадаг.

Аймаг, нийслэлийн Засаг дарга энэхүү төсвийн удирдамжийг хүлээн авч Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн төсөл боловсруулахтай холбоотой бусад заавар, чиглэлийг сум, дүүрэгтээ хүргүүлэхээр журамд заасан байдаг. Ийнхүү орон нутгийн төсвийн төсөл боловсруулах үйл явц төсвийн удирдамж хүлээн авснаар эхэлдэг гэж үзэж болно.

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 4.3-т орон нутгийн төсвийн төсөл боловсруулах цаглабарыг тусгасан байдаг.

Хүснэгт 5. Орон нутгийн төсвийн саналыг боловсруулж, хүргүүлэх цаглабар

<i>Төсвийн захирагчийн түвшин</i>	Төсвийн саналын төрөл	Төсвийн саналыг хүргүүлэх хугацаа	Хүргүүлэх төсвийн захирагч, байгууллага
Орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч	Орон нутгийн төсвийн байгууллагын суурь төсвийн санал	Жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор	Сум, дүүргийн Засаг даргад
Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа улсын төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсөвт байгууллагын суурь төсвийн санал		
Сум, дүүргийн Засаг дарга	Орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн	Жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргад
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Төлөөлөн гүйцэтгэх гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг	Жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор	Холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид
	Орон нутгийн төсөвт байгууллагын суурь төсвийн саналыг ■ Үүнээс удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн суурь зардлын санал	Жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	Сангийн яаманд
	Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоод, гадаадын хандив, тусламж авахаар бол холбогдох гэрээ, хэрэгжүүлэх хөтөлбөрийг төсвийн захирагч бүрээр боловсруулж, төсвийн төслийн хамт		
Сангийн яам	Орон нутгийн суурь төсвийн дэлгэрэнгүй мэдээлэл (улсын төсвийн төсөлд туссан орон нутгийн төсөв)	Жил бүрийн 10 дугаар сарын 5-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргад
Сангийн яам	Тухайн аймаг, нийслэлд ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг, төвлөрүүлэх орлогын хэмжээ, санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, ТЗШ-ийн хэмжээ	УИХ-аас төсөв хэлэлцэж баталснаас 14 өдрийн дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргад
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулж, танилцуулгын хамт	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн ИТХ-д

Аймаг, нийслэлийн Засаг дарга	Тухайн шатны төсвийн төслийг	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Аймаг, нийслэлийн аудитор
Аймаг, нийслэлийн аудитор	Жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн ИТХ-д

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 4.3 дахь заалт

Засгийн газраас УИХ-д улсын төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор өргөн мэдүүлдэг бөгөөд сангийн яам орон нутгийн төсвийн суурь орлого, зарлага, санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлэг зэрэг орон нутгийн төсвийн дэлгэрэнгүй мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 10 дугаар сарын 05-ны дотор хүргүүлнэ.

2.3. ИТХ-аар орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах үе шат

Сангийн яам нь УИХ-аар жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор улсын төсөв батлагдсанаас хойш 14 хоногт багтаан төсөв хоорондын шилжүүлгийн батлагдсан тооцоог буюу улсын төсөв, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ, аймаг, нийслэлийн төсвөөс орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ зэрэг мэдээллийг аймаг, нийслэлд хүргүүлдэг. Аймаг, нийслэлийн төсөв батлагдсаны дараа сум, дүүрэгт суурь төсвийн задаргааг мөн хүргүүлнэ.

Төсвийн байгууллага энэхүү хүргэгдсэн суурь төсвийн задаргааг үндэслэн 11-12 саруудад дараа жилийн төсвийг тооцон, түүнд шаардлагатай сарын санхүүжилтийн хуваарийг бэлтгэнэ. Ийнхүү төсвийн төслийг бэлтгэхдээ дээд шатнаас ирүүлсэн суурь зардлыг эдийн засгийн ангилал хооронд зөвшөрөгдсөн хүрээнд, өр үүсгэхгүйгээр хөдөлгөөнд оруулах эрхтэй ба төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлнэ.

Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын хувьд цалин хөлстэй холбоотой зардал болон нэг удаагийн тэтгэмж урамшуулал, Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээнд тусгагдсан бусад зардалд өөрчлөлт оруулах боломжгүй ба гэрээнд тусгагдсан чиглэл зарчмыг удирдлага болгоно. Мөн төсвийн хуулиар олгогдсон төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагчийн эрхээ хэрэгжүүлэх боломжтой.

Төсвийн хуулиар төсөв батлах эрх бүхий байгууллага буюу ИТХ төсвийг батлахдаа тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагчид, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батална. Төсөв батлагдахад Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих хөрөнгө оруулалт ба орон нутгийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалтын жагсаалтыг тусад нь хавсралтаар баталдаг. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр журмын хавсралт маягтыг ашиглана.

Хүснэгт 6. Орон нутгийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах цаглабар

Орон нутгийн төсвийн төсөл	Засаг дарга ИТХ-д өргөн мэдүүлэх хугацаа	ИТХ тухайн шатны төсвийн хэлэлцэн батлах хугацаа
Аймаг, нийслэлийн дараа жилийн төсвийн төсөл	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор
Сум, дүүргийн дараа жилийн төсвийн төсөл	Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор	Жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь УИХ-аар улсын төсөв батлагдсанаас хойш 10 хоногт багтаан аймаг, нийслэлийн дараа жилийн төсвийн төслийг, харин сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн ИТХ-аар төсөв батлагдсанаас хойш 5 хоногийн дотор сум, дүүргийн төсвийн төслийг эцэслэн боловсруулж, тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлдэг. Энэ нь тухайн шатны ИТХ орон нутгийн төсвийн төслийг хүлээн аваад 10 хоногийн хугацаанд танилцан хэлэлцэж, батлах боломжийг олгож байгаа юм.

Орон нутгийн төсөв батлах талаарх ИТХ-ын бүрэн эрх

68.1. Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална.

68.2. Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29-р зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.

68.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээнэ.

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 68-р зүйл

Аймаг, нийслэлийн ИТХ нь Засаг даргын өргөн мэдүүлсэн дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 5-ны дотор, харин сум, дүүргийн ИТХ нь жил бүрийн 12 дугаар сарын 10-20-ны өдрүүдэд хэлэлцэн баталж, тогтоол гаргана. Тухайлбал, сумын ИТХ нь орон нутгийн төсвийг баталсан тогтоолдоо дараах зүйлсийг заавал тусган гаргадаг. Үүнд:

- 1) Сумын тухайн оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээ
- 2) Сумын тухайн оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээ
- 3) Сумын тухайн оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээ
- 4) Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээ
- 5) Сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ
- 6) Урьд оны үлдэгдлээс санхүүжих урсгал зардлын дүн, хөрөнгийн зардлын дүн
- 7) Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн
- 8) Сумын хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
- 9) Төсөвтэй холбоотой бусад заалт.

Төсвийн тухай хуулиар сум, дүүргийн Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын 7 өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэхээр заажээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ төсвийн төслийг хэлэлцэн батлах үйл ажиллагааг хурлын дотоод дэгээр зохицуулах бөгөөд тухайн хурлын онцлог байдалд тохируулан төсөв хэлэлцэж батлах тусгай журам гарган мөрдөж болно.

Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн аймаг, нийслэлийн төсвийг батлагдсан өдрөөс хойш ажлын 3 өдөрт сум, дүүргийн Засаг даргад, сум, дүүргийн Засаг дарга тухайн жилийн сум, дүүргийн төсвийг батлагдсан өдрөөс хойш ажлын 3 өдөрт аймаг, нийслэлийн Засаг даргад нэгтгүүлэхээр хүргүүлнэ.

Төсвийн тухай хуулийн 8.5.5-д аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн батлагдсан төсвийг 12-р сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Сангийн яам)-д хүргүүлэхээр заасан байдаг.

Сум, дүүргийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 9.1-д заасан зүйлийг харгалзан төсвийн ангилал бүрээр, боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад батлагдсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга жилийн төсвийн сар, улирлын хуваарийг нэгтгэн жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.

Төсвийн төсөлд тавигдах шаардлага, бүтэц, агуулга

Орон нутгийн төсвийн төсөл гэдгийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн, хуульд заасан шаардлагын дагуу төсвийн шатлал бүрээр төсвийн ангилал ашиглан бүх шатны Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн санал гэж ойлгоно.

Орон нутгийн төсвийн төсөлд тавигдах шаардлага

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг боловсруулж, тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэх, орон нутгийн төсвийн байгууллага болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих улсын төсвийн байгууллагын төсвийн захирагч жилийн төсвийн төслийг боловсруулж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх, батлагдсан төсвийг дээд шатны байгууллагад хүргүүлэх, олон нийтэд мэдээлэхдээ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Дээрх журмын 7.1 дэх заалтад орон нутгийн дараа жилийн төсвийн төсөл нь дараах шаардлагыг хангасан байхаар журамлажээ. Үүнд:

- Үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх;
- Төсвийн тэнцэл алдагдалгүй байх;
- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;
- Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;
- Худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх шаардлагууд хамаарна.

Мөн орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байхаар заажээ.

Байгууллага дээд шатнаас ирсэн суурь төсвийн төслийг үндэслэн төсвийн төслөө боловсруулах зарчим баримтална. Өөрөөр хэлбэл, төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь байгууллагуудын төсвийн төслийг

боловсруулахдаа эдийн засгийн ангилал хооронд хөдөлгөөн оруулах эрхийнхээ хүрээнд ажиллаж, өр үүсгэх хэмжээний хөдөлгөөнийг хийхгүй байх шаардлагатай юм.

Төсвийн тухай хуулиар төсвийн удирдамжийн тухай ойлголт бий болсон. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Сангийн яам) төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн төсөл бэлтгэх удирдамж хүргүүлэх ба тус удирдамжид орон нутгийн төсвийн төсөл бэлтгэх нарийвчилсан зааврыг тусган, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлдэг бол аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Засаг даргад удирдамж хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг даргаас хүргүүлэх удирдамжид өөрийн мөрийн хөтөлбөр, төлөвлөлтийн бусад шаардлага, төсвийн төслийн санал хүргүүлэх хугацаатай холбоотой бусад заавар, чиглэлийг тусган холбогдох төсвийн захирагчид хүргүүлэх боломжтой. Төсвийн төслийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулж боловсруулах бөгөөд Төсвийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж батлуулах хугацаа, дараалал хуульчлагдсаныг дагаж мөрдөнө. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан улсын хэмжээний нэгдсэн төсвийн үзүүлэлтээр орлого, зарлага, төсвийн тэнцлийн үзүүлэлт, улсын өрийн дээд хязгаар гэх мэт мэдээллийг багтаан баталдаг байна. Иймд төсвийн задаргаа болон саналыг авдаггүй.

УИХ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 1-ний дотор хэлэлцэж, батладаг бол Засгийн газар төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн зарлагын хязгаарыг 7 дугаар сарын 1 гэхэд батлахаар хуульчлагджээ. Зарлагын хязгаарыг боловсруулах үе шатанд төсвийн тухай хуулийн 8.3 дахь заалтыг мөрдөх бөгөөд уг батлагдсан зарлагын хязгаарын мэдээллийг Сангийн яамнаас төсвийн ерөнхийлөн захирагчид 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн удирдамжийн хамт хүргүүлэхээр хуульчилсан байна.

Энэхүү Төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан, Засгийн газраар батлагдсан зарлагын хязгаарт орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг зэрэг нь нийт дүнгээрээ батлагдаж, аймаг, нийслэлд төсвийн удирдамжийн хамт хуулийн хугацаанд хүргэгдэнэ. Аймаг, нийслэл нь хүлээн авсан төсвийн удирдамж, улсын төсвөөс олгох шилжүүлгийн дүнг сум, дүүрэгтээ ажлын 3 хоногт багтаан хүргүүлэхээр журамласан байдаг. Өөрөөр хэлбэл, дараа жил нь улсын төсвөөс хүлээн авах улсын төсвийн шилжүүлгийн нийт дүн 7 дугаар сарын дундуур орон нутгийн байгууллагуудад урьдчилсан байдлаар тодорхой болдог гэсэн үг.

Үүнтэй зэрэгцэн орон нутгийн байгууллагууд дараа жилийн төсвийн дэлгэрэнгүй тооцооллоо хийж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэхээр бэлтгэж байдаг бөгөөд хүлээн авсан нийт дүнгийн мэдээлэлд үндэслэн төсвөө тооцох, холбогдох саналаа боловсруулдаг болсон юм.

Орон нутгийн төсвийн төслийн бүтэц, агуулга

Орон нутгийн төсөв нь тухайн орон нутгаас санхүүждэг байгууллагуудын төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагын төсвийн бүрдэл юм.

Тухайн шатны Засаг дарга ИТХ-д орон нутгийн төсвийн төслийг өргөн мэдүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 32.2 дахь заалтад тусгагдсан зүйлсийг төсвийн төслийн танилцуулгад оруулсан байхаас гадна Төсвийн тухай хуулийн 67.1-67.3 дахь заалтын дагуу дараах зүйлсийг нэмж тусгах шаардлагатай. Үүнд:

- 1) Орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;

- 2) Хуульд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга;
- 3) Аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн санал;
- 4) Дээд шатны төсөвт тусган баталсан дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, дээр дурдсан зүйлсийг багтаасан танилцуулгын хамт тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ. Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг ИТХ-д танилцуулна (Төсвийн тухай хуулийн 67.1, 67.3 дахь заалт).

Орон нутгийн төсвийн танилцуулгад дараах мэдээлэл тусгагдсан байх шаардлагатай. Үүнд:

- 1) Төсвийн тэнцлийн үзүүлэлтийг тооцсон байдал
- 2) Төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдлийн үнэлгээ
- 3) Татварын орлогын тооцоолол
- 4) Хөрөнгө оруулалтын жагсаалт
- 5) Санхүүжилтийг зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, төсөвт үзүүлэх нөлөөлөл
- 6) Ногдол ашгийн хэмжээ
- 7) Хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, орц, хүрэх үр дүн гэх мэт.

Орон нутгийн төсвийн төсөлд 3-аас доошгүй жилийн төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг харуулсан байх нь тухайн жилийн төсвийн өөрчлөлтийг харьцуулан харах боломжийг олгоно. Энэ мэдээлэлд үндэслэн жил бүрийн төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийн өөрчлөлтөд нөлөөлж байгаа нөлөөллийг судалж мэдэх шаардлагатай бөгөөд үүнийг ИТХ-аас төсвийг батлах шийдвэр гаргахдаа харгалзан үзэх хэрэгтэй.

Аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн төсвийн төсөл нь дараах хүснэгтэд харуулсан бүтэц, агуулгатай байна.

Хүснэгт 7. Аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн төсвийн төслийн бүтэц, агуулга

<i>Аймаг, нийслэлийн төсвийн төсөл</i>	<i>Сум, дүүргийн төсвийн төсөл</i>
1. Аймаг, нийслэлийн Засаг дарга өөрийн төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын тухайн жилд олох орлогын хэмжээг дараах байдлаар тооцсон байна. Үүнд: - аймаг, нийслэлийн төсвийн нийт орлогын дүнг нэр, төрлөөр; - төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлогын хэмжээ, харьяалах төсөвт байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээгээр. 2. Аймаг, нийслэлийн Засаг дарга урсгал зарлага, хөрөнгийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дээд хэмжээг төсвийн захирагч бүрээр тооцсон байна. 3. Бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дараах байдлаар тооцно. Үүнд:	1. Сум, дүүргийн Засаг дарга өөрийн төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын тухайн жилд олох орлогын хэмжээг дараах байдлаар тооцсон байна. Үүнд: - сум, дүүргийн төсвийн нийт орлогын дүнг нэр, төрлөөр; - төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяалах төсөвт багууллагын өөрийн орлогын хэмжээ, харьяалах төсөвт байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээгээр. 2. Сум, дүүргийн Засаг дарга урсгал зарлага, хөрөнгийн зарлагын дээд хэмжээг төсвийн захирагч бүрээр тооцож гаргасан байна. 3. Сум, дүүргийн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ, орон нутагт Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлж буй улсын төсөвт байгууллагад

- аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийн хэмжээг сум, дүүрэг тус бүрээр; - аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг сум, дүүрэг тус бүрээр; - аймаг, нийслэлийн төсөвт сум, дүүргийн төсвөөс татан төвлөрүүлэх орлогын хэмжээг сум, дүүрэг тус бүрээр; - аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг зориулалтын чиг үүрэг, сум, дүүрэг тус бүрээр; - аймаг, нийслэлийн төсвөөс ОНХС-д хөрөнгө төвлөрүүлэхээр бол орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээгээр. 4. Урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зардлыг зарлагын томсгосон ангиллаар тооцсон байна. 5. Аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж, дараах зүйлийг тусгана. Үүнд: - төсвийн захирагчийн нэр; - хөтөлбөрийн нэр; - тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт; - тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт; - зарцуулах төсөв.	олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг дараах байдлаар тооцно. Үүнд: - сум, дүүргийн төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг хөтөлбөрөөр, төсвийн захирагч бүрээр; - сум, дүүргийн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээгээр. 4. Сум, дүүргийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулан, дараах зүйлийг тусгана. Үүнд: - төсвийн захирагчийн нэр; - хөтөлбөрийн нэр; - тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт; - тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт; - зарцуулах төсөв. 5. Сум, дүүргийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулан, дараах зүйлийг тусгана. Үүнд: - төсвийн захирагчийн нэр; - хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр; - байршил; - хүчин чадал; - хэрэгжүүлэх хугацаа; - төсөвт өртөг; - санхүүжүүлэх эх үүсвэр; - тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн.
--	--

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын төсөвт тавигдах шаардлага

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх эрхийг Төсвийн тухай хуулиар олгосон байдаг. Мөн төсвийн хуулийн хариуцлагатай байх зарчимд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр төсвийн хуульд заасан чиг үүргээс бусад чиг үүргийг өөр хууль тогтоомжоор тогтоосон бол тухайн чиг үүргийг санхүүжилтийнх нь хамт шийдвэрлэн шилжүүлдэг байхаар хуульчилсан байна. Иймд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд санхүүжилтийн эх үүсвэртэйгээ орон нутагт шилждэг гэсэн үг.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацаанд багтаан зохих шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ. Энэ хүрээнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь Засаг даргын өргөн мэдүүлсэн саналд үндэслэн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр хуваарилсан санхүүжилтийг гэрээний дүнгээс бууруулахгүйгээр орон нутгийн төсвийн нэг хэсэг болгож батална.
- Аймаг, нийслэлийн Засаг даргатай Төсвийн тухай хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 14

өдрийн дотор холбогдох салбарын сайд буюу төсвийн ерөнхийлөн захирагч байгуулна.

- Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Засаг даргатай төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг сум, дүүргийн түвшинд аймаг, нийслэлийн төсөв батлагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор байгуулна.
- Гэрээнд чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхдээ тусгай зориулалтын шилжүүлгийг бусад салбарын санхүүжилтэд шилжүүлэхгүй байх, өр, авлага үүсгэхгүй, үйлчилгээний стандарт, тоо хэмжээ, чанар, хүртээмжийг бууруулахгүй байх зэрэг асуудлыг тусгана.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гэрээнд тусгагдсан чиглэл зарчмыг удирдлага болгоно.
- Төсвийн хуулиар олгогдсон төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагчийн эрхээ хэрэгжүүлэх боломжтой.

Мөн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого буюу үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг тухайн шатны ИТХ-аар батлуулж зарцуулна. Хамгийн сүүлд батлагдсан төлөвлөгөө нь жилийн эцсийн тайлангийн төлөвлөгөө гэсэн баганад тусгагдана. Төсвийн байгууллага нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр, төлбөр үүсгэхгүйгээр хөтөлбөр, арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зарцуулна.

Орон нутгийн төсвийн тодотгол

Төсвийн тухай хуулиар орон нутаг төсвийн эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар төсвөө тухайн шатандаа батлуулан хэрэгжүүлэх боломжтой болсон төдийгүй жилийн эцэст дансны үлдэгдлээ ерөнхий дансандаа төвлөрүүлэн зарцуулах боломжтой болсон бөгөөд төсвийн тодотгол хийх нөхцлүүд хуулиар хязгаарлагдсан.

Дараах тохиолдолд л орон нутаг төсөвтөө тодотгол хийх боломжтой. Үүнд:

- Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон. Өөрөөр хэлбэл сум, дүүргийн хувьд аймаг, нийслэл төсвөө тодотгосны дараа, аймаг, нийслэлийн хувьд улсын төсөвт тодотгол хийгдсэний дараа төсвөө тодотгоно.
- Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон;
- Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах
- Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх зэрэг орно.

Шаардлагатай гэж үзвэл тухайн жилийн төсөвт тодотгол хийж дуусах хүртэлх хугацаанд дараах хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийг түр зогсоож болно. Үүнд:

- Санхүүжүүлэх хэмжээ нь багасахаар, эсвэл хасагдахаар төсвийн тодотголын төсөлд тусгасан;
- Тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй.

Дээд шатны төсөвт тодотгол орсны улмаас доод шатны төсвийн захирагч батлагдсан төсөвтөө зайлшгүй тодотгол оруулах шаардлагатай гэж үзвэл дээд шатны төсөвт тодотгол орсноос хойш 45 хоногт багтаан төсвийн тодотголын төслийг зөвхөн нэмэлт, өөрчлөлт оруулж буй орлого, зарлагаар харуулан бэлтгэж, төсвийн төслийн

нэгэн адил боловсруулж, тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ. Өөрөөр хэлбэл, ямар эдийн засгийн ангиллын орлого, зарлага нэмэгдэж, хасагдаж байгааг анх батлагдсан төсөвтэй зэрэгцүүлэн харуулсан байх шаардлагатай болдог.

Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн тодотголын төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэн баталснаас хойш 30 өдрийн дотор сар, улирлын хуваарийг баталж, нэгтгэн санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (Сангийн яам)-д хүргүүлнэ.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн агуулга, бүтэц

Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг дарга тухайн шатны ИТХ-д өмнөх жилийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг өргөн барьж төсвийн гүйцэтгэлийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулдаг. Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна (Төсвийн тухай хуулийн 54.5). Үүнд:

- Тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл (нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр);
- Татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт;
- Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;
- Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга (хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан);
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга зэрэг хамаарна.

Төсөвт зохицуулалт хийсэн тохиолдолд хөтөлбөрийн гүйцэтгэлийг анх төлөвлөсөн хүрэх үр дүнгийн зорилттой нь харьцуулсан байдлаар тайлагнана. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.

ИТХ-аар орон нутгийн төсвийг хэлэлцэн батлахад анхаарвал зохих зүйлс

- Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэйгээр тооцож батлах, хийсвэрээр өсгөхгүй байх;
- Хууль тогтоомжоор тухайн шатны хуралд олгогдсон эрх хэмжээний хүрээнд төлбөр, хураамж ногдуулах, цуглуулах асуудлыг шийдвэрлэх;
- Орон нутгийн төсвийн байгууллагын болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих улсын төсөвт байгууллагын зардлыг үндэслэл, тооцоогүйгээр өсгөж батлахгүй байх;
- Эх үүсвэргүй урсгал болон хөрөнгийн зардал батлахгүй байх;
- Төсвийн шийдвэрийг гаргахдаа орон нутгийн хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, иргэдээс гарсан саналд тулгуурлан нийтийн эрх ашигт нийцсэн төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд анхаарах нь чухал.
- Төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс Төсвийн тухай хуулийн 29-р зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авч тусгана гэж хуульчилсан байдаг. Өөрөөр хэлбэл, ИТХ-аар төсвийг хэлэлцэхдээ шинээр хэрэгжихээр төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орсон төсөл тус бүрийн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, зохих зөвшөөрлүүд нь олгогдсон эсэхийг нягтална.
- Мөн тухайн хөрөнгө оруулалт нь ашиглалтад орсноор урсгал зардал, орон тоог нэмэгдүүлэхээр байна уу? гэдэг дүгнэлт хийгдсэн байх шаардлагатай бөгөөд хэрэв

нэмэгдүүлэхээр бол тэрхүү зардлыг цаашид ямар эх үүсвэрээс шийдвэрлэх талаар тооцоо, тайлбарыг авч үзэх шаардлагатай.

- Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн эхний жилд тавигдах санхүүжилт нь төсөвт өртгийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан дүнгээс багагүй байхаар тусгах шаардлагыг хуульчилсан тул хөрөнгө санхүүгийн боломжоо тооцох учиртай юм. Жишээлбэл, ЗДТГ-т их засвар хийх 200 сая төгрөгийн 2 жил хэрэгжүүлэх төсөл хэрэгжүүлнэ гэвэл эхний жилдээ 100 сая төгрөг нь тусгагдсан байхыг шаардана гэсэн үг.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хувьд ИТХ-аар хэлэлцэх явцад иргэдийн саналыг аваагүй төслийг шинээр нэмж тусгах боломжгүй.

2.4. Орон нутгийн төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг зохион байгуулах үе шат

Төсвийн гүйцэтгэлийн үе шат нь Төсвийн тухай хууль болон орон нутгийн төсвийн журмын дагуу төсвийн орлогыг дайчлан оруулах, зарлагыг төсөвлөсөн үйл ажиллагаанд зарцуулах буюу төсвийн хөрөнгийг ашиглахаас эхлэн тайлан гаргах хүртэлх хугацааг хамарна.

Төсвийн гүйцэтгэлийг хангах гэдэг нь санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан орлогын эх үүсвэрийг холбогдох субъектүүдээс хугацаанд нь зохих шатны төсөвт татан оруулах, төлөвлөгөөт санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай, аливч хямгачаар зарцуулах үйл ажиллагаа юм. ИТХ-аас тухайн жилийн төсвийг баталсан тухай тогтоол гарснаар орон нутгийн төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг зохион байгуулах үе шат эхэлнэ. Гүйцэтгэлийн явцад төсвийн байгууллагууд батлагдсан төсвөө зарцуулж, үйлчилгээ үзүүлдэг. Батлагдсан төсөв нь төсвийг зарцуулах үйл ажиллагааг хянахад чухал ач холбогдолтой байдаг.

Манай улсад төсвийн жил 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд үргэлжилдэг. Энэ хугацаанд орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн үе шат үргэлжлэх ба энэ үе шатанд:

- Аймаг, сумдын Засаг дарга нар төсвийн орлогын төлөвлөгөөний дагуу орлогын эх үүсвэрийг зохих шатны төсөвт төвлөрүүлэх;
- Тухайн шатны төсөвтэй харилцагч төсөвт байгууллагын төсвийн шууд захирагчтай Засаг дарга үр дүнгийн гэрээ байгуулж санхүүжилтийг олгох;
- Сумдын Засаг дарга нар аймгийн Засаг даргатай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх гэрээгээ хэрэгжүүлэх үүднээс тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй улсын төсөвт байгууллагуудын шууд захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулан аймгийн Засаг даргатай байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах;
- Орон нутгийн төсөвт байгууллагууд хүрэхээр тодорхойлсон зорилго, зорилгоо болон төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Үр дүнгийн гэрээ”-гээ биелүүлэх зорилгоор батлагдсан төсвийг үр дүнтэйгээр захиран зарцуулах;
- Орон нутгийн төсөвт байгууллагын түвшинд сар бүрийн эцэст тухайн сарын санхүүжилтийг тайлагнах төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргах;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн ба байдлыг харуулах санхүүгийн тайланг улирал бүр гаргах, төлөөлөн гүйцэтгэх гэрээ, үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг харуулах тайланг улирал бүр гаргах;

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд буюу тухайн шатны Засаг дарга улс, орон нутгийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн тайланг хагас, бүтэн жилээр гарган дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх зэрэг үйл ажиллагаа явагдана.

Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.

Төсвийн тухай хууль болон бусад заавар, журмуудад төсвийн байгууллага батлагдсанаас илүү төсөв зарцуулахыг хориглодог. Батлагдсанаас бага төсөв зарцуулах нь үр ашигтай үйл ажиллагааг илтгэж болох авч, нөгөө талаас, төлөвлөсөн ажил, үйлчилгээ хэрэгжээгүй, эсвэл тухайн байгууллагын төсвийг бодитой төлөвлөж чадаагүйг харуулж болно. Иймээс ИТХ-ын Төлөөлөгчид, санхүүгийн ажилтнууд жилийн туршид батлагдсан зардал болон бодит зардал (зардлын гүйцэтгэл) хоёрын харьцааг үргэлж хянаж байх ёстой. Төсвийн хэрэгжилтийн үйл явцад ажиглагддаг түгээмэл үзэгдэл бол зардал хэтрэх явдал юм. Ийм байдал үүсгэхгүйн тулд явцын дунд хяналт шинжилгээг сайжруулж, зардлыг зөв төлөвлөх нь чухал байдаг.

Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн төсөвтэй холбоотой тодорхой зохицуулалт үйлчилдэг. Тухайлбал, Сангийн яам нь аймаг, нийслэлийн төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум, дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийг дараах зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгах хүртэлх хугацаанд түр зогсоох эрхтэй. Үүнд:

- Төсвийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн;
- Иргэдийн төлөөлөгчдийн хурал тухайн жилийн төсвөө үндэслэлгүйгээр нэмэгдүүлж баталсан;
- Тусгай зориулалтын шилжүүлгийн зориулалт, зарцуулалтын нөхцөл, шаардлагыг зөрчсөн;
- Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандартыг мөрдөөгүйгээс нийт төсөв нь алдагдалтай гарсан;
- Орон нутгийн төсвийн тогтвортой байдал алдагдсан;
- Орон нутгийн төсвийг энэ хуулиар тогтоосон хугацаанд батлаагүй.

Дээрх нөхцөл үүссэн тохиолдолд зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилт болон орон нутгийн төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн харилцаанд оролцогчдын чадавхийг дээшлүүлэх зорилгоор Засгийн газар болон аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагт тогтворжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр хуульчлагдсан байна.

Төсвийн тухай хуулийн төсвийн зарчим, түүнийг хэрэгжүүлэх, төсвийн жилийн талаарх 5-7 дугаар зүйл “Төсвийн хэрэгжилт, гүйцэтгэл” гэсэн 6 дугаар бүлгийн 35-47 дугаар зүйлд төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн явцын гол зохицуулалт болох төрийн сангийн нэгдсэн данс, төрийн сангийн тогтолцоо, төрийн сангийн нийтлэг чиг үүрэг, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, үр дүнгийн гэрээ, төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх, төсвийн жил дамжин хэрэгжих арга хэмжээний зохицуулалт, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагаа, төсвийн зарлагын хэмнэлт, төсвийн урамшуулал, нэмэлт төсвийн асуудлыг нарийвчлан тусгаж өгсөн байна.

Төрийн сангийн үйл ажиллагаа

Төрийн төсөв, санхүүгийн хөрөнгийг Монгол банкинд байрших Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан удирдана. Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогчдоос бүрдэнэ.

Төрийн сангийн чиг үүрэг (Төсвийн тухай хуулийн 37.1 дэх заалт)

- төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих;
- төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх;
- төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх;
- төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох;
- төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих;
- төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх;
- төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах;
- төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох

байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.

Төсөвт зохицуулалт хийх

Төсөвт зохицуулалт хийхдээ “Төсвийн тухай хууль”-ийн 42 дугаар зүйл болон болон Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг дагаж мөрдөнө. Төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, төсвийн хүндрэлийг давах зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч нь:

1. Өөрийн төсвийн багцад хамаарах хөтөлбөр хооронд;
2. Түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд;
3. Төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;
4. Түүнд шууд харьяалагдах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд зохицуулалт хийнэ.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд зохицуулалт хийх боломжтой бол төсвийн шууд захирагч нь зөвхөн өөрийн урсгал зардалд зохицуулалт хийнэ.

Төсвийн шууд захирагч нь зохицуулалт хийх саналаа аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тус тус хүргүүлж, Засаг дарга зохицуулалтын саналыг хянаж, зөвшөөрсний дагуу төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэнэ. Энэ зохицуулалтын эрхийг ашигласнаар төсвийн байгууллага өр, авлага үүсгэхгүй байх боломжтой болдог. Тухайлбал, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга нар бөгөөд харьяалагдах төсвийн шууд захирагчийн төсөвт зохицуулалт хийх асуудлыг өөрийн баталсан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэнэ.

Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг Төсвийн хуулиар хориглодог байна. Мөн цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж болон хойшлогдсон, эсвэл зарцуулагдаагүй нэг удаагийн арга хэмжээний зардлыг бусад зардлын зүйлд шилжүүлэн зарцуулахгүй байх зарчим баримтална. Эдгээр зардалд зохицуулалт хийх бол Төсвийн ерөнхийлөн захирагчид хандан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлнэ.

Төсвийн байгууллагын эдийн засгийн ангиллаарх зардлыг байгууллагын тогтмол зардал, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал, эд хогшлын зардал,

томилолт зочны зардал, бусад бараа үйлчилгээний зардлын бүлгүүдэд ангилах болсон бөгөөд батлагдсан төсвийн тухайн зардлын бүлгийн дүнг 20 хувиар нэмэгдүүлэх зохицуулалтын хүсэлт гаргах, түүнийг нь санхүүжилтийн хуваариар баталж хэрэгжүүлэх боломжтой болсон байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн байгууллагаас ирүүлсэн 10 сая төгрөг хүртэлх зохицуулалт хийх хүсэлтийг судлан, зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд зохицуулалтыг хийх бол төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төсвийн байгууллагаас ирүүлсэн 20 сая төгрөг хүртэлх зохицуулалтыг хийнэ.

Төсвийн хуульд зааснаар шилжүүлгийн нийт дүнгийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг сум, дүүрэг нь аймаг, нийслэлдээ гаргах бол аймаг, нийслэл нь тусгай зориулалтын шилжүүлгийг хариуцсан салбарынхаа Төсвийн ерөнхийлөн захирагчид нь, санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийг Сангийн яаманд гаргаж, санхүүжилтээ шийдвэрлүүлнэ.

Сум, дүүргийн төсвийн орлогын улирлын чанартай дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн төсвөөс богино хугацаатай зээл олгож болох төдийгүй санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулан тухайн сарын санхүүжилтээ нэмэгдүүлэх хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргад гаргах боломжтой.

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт

Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл явц нь дараах үе шатуудаар хэрэгжинэ. Үүнд:

- Орон нутгийн төсөв батлагдсаны дараа жилийн худалдан авах ажиллагааныхаа төлөвлөгөөг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний мэдээллийг олон нийтэд зарлан мэдээлэх;
- Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг зохих босго үнээс давсан бол үнэлгээний хороог байгуулах;
- Босго үнэтэй нийцүүлэн худалдан авах ажиллагааны аргыг сонгох;
- Тендерийн баримт бичгийг бэлтгэх, урилгыг зарлан мэдээлэх;
- Тендерийг хүлээн авах, нээх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлэх;
- Гэрээ байгуулах, гэрээг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- Худалдан авах ажиллагааны хавтаст хэрэг бүрдүүлж, архивт шилжүүлэх, тайлагнах зэрэг болно.

Орон нутагт хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах эхний шатанд тухайн төслийн босго үнийг авч үзнэ. Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан босго үнийг бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад баримтална. Хэрэв бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртөг нь 10 сая төгрөгөөс доош бол шууд худалдан авалт хийж болно. Харин бараа 50 сая төгрөг хүртэл, ажил 80 сая төгрөг хүртэл, үйлчилгээ 50 сая төгрөг хүртэл бол харьцуулалтын аргыг ашиглах, эдгээрээс дээш төсөвт өртөгтэй бол нээлттэй тендер шалгаруулалтын аргыг ашиглана.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан

Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг боловсруулж, хүргүүлэх, төсвийн улирал, хагас, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг тайлагнах хугацаа, цаглабарыг мөрдөж ажиллах үүргийг төсвийн захирагч нар хүлээдэг.

Орон нутгийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг дараах цаглабрын дагуу боловсруулж, хүргүүлдэг.

- 1) Төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 2-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлнэ;
- 2) Төсвийн төвлөрүүлэн захирагч тусгай сан, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 4-ний дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ;
- 3) Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 6-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9 дэх заалтын дагуу төсөв захирагчид төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараах цаглабрын дагуу тайлагнана.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг боловсруулах цаглабар

8.9.1. төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;

8.9.2. төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

8.9.3. сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны төсвийн хагас жилийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны дотор дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;

8.9.4. аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;

8.9.5. төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

Төсвийн тухай хуулийн 8.9 дэх заалт

Төсвийн ил тод байдлыг хангах шаардлага, цаглабар

Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2011 оны 12-р сард батлагдсанаар төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, төсвийн

ил тод байдал, ялангуяа төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар томоохон өөрчлөлт хийх нөхцөл бүрдсэн юм. Тухайлбал, уг хуулийн 6-р зүйлд төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг хэрэгжүүлэхдээ төсвийг хэлэлцэн батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх; төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах; төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах; төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байхыг хуульчилжээ.

Түүнчлэн УИХ-аас Шилэн дансны тухай хуулийг 2014 онд батлан гаргаж, энэхүү хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталжээ. Энэ журам нь шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоож, уг цахим хуудсанд мэдээлэл тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготойгоос гадна төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нь шилэн дансны цахим хуудсанд хууль, журамд заасны дагуу холбогдох мэдээллийг тавих үүрэгтэй гэдгийг тогтоож өгсөн юм.

Төсвийн байгууллага мэдээллийг олон нийтэд хүргэхдээ мэдээллийн самбар, цахим болон хэвлэмэл хуудас, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглах боломжтой бөгөөд цахим болон мэдээллийн бусад хэлбэр ашиглаж байгаагаас үл хамааран мэдээллийн самбарыг заавал ажиллуулах ёстой.

Мэдээллийг нийтэд хүргэхдээ аль болох ойлгомжтой байдлаар мэдээлэх шаардлагатай байдаг. Ихэнх төсөв захирагч нар төсвийн мэдээллийг ил тод болгохдоо хүснэгтэлсэн тоог байршуулж байгаа нь иргэд ойлгох боломжгүй тул текст хэлбэрээр боловсруулж мэдээлэх нь мэдээлэл авах хэрэгцээ шаардлагыг илүү хангана.

Төсвийн байгууллага цахим хуудсандаа “байгууллагын төсөв” гэсэн цэс үүсгэн тэрхүү цэсэнд төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл болон дунд хугацааны зорилго, зорилт, үйл ажиллагааны стратегийн мэдээллүүдээ оруулах, шинэчлэн байршуулах үйл ажиллагааг тухай бүр хэрэгжүүлнэ. Мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төлөвлөлт хариуцсан нэгж тухайн шатны төсвийн сар, улирлын хуваарь, түүнд хийсэн зохицуулалтын тухай цахим хэлбэрээр болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлнэ.

Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.
Шилэн дансны тухай хуулийн 8.1 дэх заалт

Ийнхүү төсвийн харилцааны шинэ нөхцөлд түүний ил тод, нээлттэй байдлыг хангах зорилт чухлаар тавигдаж, орон нутгийн төсвийг ИТХ, иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоогүйгээр бодитой төлөвлөх, хянах боломжгүй болж байна. Иргэд, татвар төлөгчдийн оршин суугаа газар нутаг, өдөр тутмын ажил, амьдралтай шууд холбоотой

төсвийн үнэн зөв мэдээллийг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар өгч байх нь тэдний зүгээс төсвийн үйл явцад анхаарлаа хандуулж бүтээлчээр оролцох үндсэн нөхцөл болдог. Төсвийн талаар төрөөс, ялангуяа нутгийн удирдлагын зүгээс хүлээх хариуцлагыг тодорхой болгож, төсвийн талаарх мэдээллээр олон нийтийг хангаж, төсвийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь сайн засаглалыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

Төсвийн ил тод байдал хангагдаагүй тохиолдолд олон нийтийн оролцоо бий болохгүй бөгөөд энэ нь мөн төсвийн бодлогыг боловсруулах үйл явц дахь олон нийтийн хэлэлцүүлгийн хамрах хүрээ, агуулгыг хязгаарлах болно. Нөгөө талаас, төсвийн үйл явц ил тод байх нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагч нарт хариуцлагын мэдрэмжийг бий болгох; хариуцлагатай, шударга шийдвэр гаргадаг болгох; ирээдүйн хөгжлийн талаар илүү сайн төсөөлөл, стратегийг тодорхойлох; төсвийн төслийг цаг хугацаанд нь, үр дүнтэй боловсруулж хэрэгжүүлэхийг дэмжих; төсвийн үйл явцад хуулийн дагуу илүү сайн хяналт тавих; олон нийтийн хүсэл эрмэлзэл, итгэлийг бий болгох, түүнчлэн Засгийн газар, нутгийн удирдлага хүнийхээ төлөө ажиллах чадварыг бий болгоход хувь нэмрээ оруулдаг.

Төсвийн ил тод байдлын ойлголт нь ихэвчлэн төсвийн үйл явцын нээлттэй байдал, энэ үйл явцад олон нийтийг оролцуулах боломжтой холбоотой. Ил тод төсвийн үйл явц нь иргэд төр, орон нутгийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход оролцох боломжит орон зайг бий болгодог ч оролцоонд тулгуурлан хариуцлагатайгаар шийдвэр гаргахыг баталгаажуулна гэсэн үг биш юм. Олон нийтийн оролцоог хангахуйц байхын тулд төсвийн үйл явц нь улсын болон орон нутгийн түвшинд аль алинд нь ил тод байх хэрэгтэй.

Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу тухайн жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцыг захиалагч байгууллага цаг хугацаа алдалгүй, шуурхай, үр ашигтай зохион байгуулахад шаардлагатай болсон. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө буюу тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг нийтэд зарлан мэдээлэх, тендэрийн урилга бэлтгэх, зарлан мэдээлэх, захиалагч байгууллагуудаас ирүүлсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг www.tender.gov.mn цахим хуудсанд байрлуулна. Орон нутагт өөрийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах болон нийтийн зар мэдээний самбарт худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэл, тайланг байршуулна.

Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журамд аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэж, санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж байхаар тогтоосон байна.

Орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг ил болгох цаглабар, хэлбэр

Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл болон төсвийн баримт бичгийг олон нийтэд ил тод болгох цаглабар, төсвийн мэдээллийг ил тод болгох маягт, хэлбэрийг дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг ил болгох цаглабар

Ил тод болгох хугацаа	Төсвийн баримт бичиг ба үйл явц	Төсвийн мэдээллийг ил тод болгох маягт, хэлбэр
Сар бүрийн 8-ны дотор (жилд 12 удаа)	Төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн сар (улирал, хагас, бүтэн жил)*-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.2, 2, 20-р хавсралт (цахим)
	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессийн зүйлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.4, 3-р хавсралт (цахим)
	Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.5, 4-р хавсралт (цахим)
	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.8, 2-р хавсралт (цахим)
	Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.15 11-р хавсралт (цахим)
Жил бүрийн 1-р сарын 10-ны дотор	ТЕЗ-ийн тухайн жилийн төсвийн хөтөлбөр, батлагдсан төсөв	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.2, 2, 20-р хавсралт (цахим)
	ТЕЗ-ийн тухайн жилийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.1, 1-р хавсралт (цахим)
	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жилийн төлөвлөгөө, концессийн зүйлийн жагсаалт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.4, 3-р хавсралт (цахим)
	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.8, 2-р хавсралт (цахим)
	Тухайн оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.14 21-р хавсралт (цахим)
Жил бүрийн 1-р сарын 15-ны дотор	Өмнөх оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.14 22-р хавсралт (цахим)
Жил бүрийн 1-р сарын 10-ны дотор	Тухайн оны Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.15 11-р хавсралт (цахим)
Жил бүрийн 4-р сарын 25-ны дотор	ТЕЗ-ийн өмнөх оны төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн жилийн эцсийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.1, 1-р хавсралт (цахим)
	Өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлан (төсвийн гүйцэтгэлийн тайлан)	Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтуудаар. МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.9 (цахим, PDF форматаар)
	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.6, 5-р хавсралт (цахим)
	Өмнөх оны хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.7, 6-р хавсралт (цахим)
	Өмнөх оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.10 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 7-р сарын 1-ний дотор	Өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.11 (цахим, PDF форматаар)

Жил бүрийн 7-р сарын 15-ны дотор	Сум, дүүргийн төсвийн байгууллага (ТШЗ)-ын дараа жилийн төсвийн санал	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.3 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 7-р сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн төсвийн байгууллага (ТШЗ)-ын дараа жилийн төсвийн санал	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.3 (цахим, PDF форматаар)
	Сум, дүүргийн төсвийн зрөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч (ТЕЗ, ТТЗ)-ын дараа жилийн төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 8-р сарын 1-ний дотор	Аймаг, нийслэлийн төсвийн төвлөрүүлэн захирагч (ТТЗ)-ын дараа жилийн төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 8-р сарын 15-ны дотор	Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн дараа жилийн төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан хагас жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.6, 5-р хавсралт (цахим)
	2015 оны хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.7, 6-р хавсралт (цахим)
	2015 оны хагас жилийн санхүүгийн тайлан (төсвийн гүйцэтгэлийн тайлан)	Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтуудаар. МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.9 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 9-р сарын 15-ны дотор	2016 оны төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 9-11-р сард	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр дараа жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал асуулга явуулж, иргэд, олон нийтийн санал авах явц, урьдчилсан жагсаалт боловсруулж хэлэлцүүлэх, өргөн барих үйл явц, үр дүнгийн мэдээлэл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.15 11-р хавсралт (цахим)
Жил бүрийн 11-р сарын 10-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргаас Аймаг, нийслэлийн ерөнхий аудиторт хүргүүлсэн дараа жилийн төсвийн төсөл	ТЕЗ-ын төсвийн төсөл, төсвийн төсөөлөл боловсруулах удирдамжийн хавсралт
Жил бүрийн 11-р сарын 25-ны дотор	Дараа жилийн төсвийн төсөлд аймаг, нийслэлийн ерөнхий аудиторын өгсөн дүгнэлт	Аймаг, нийслэлийн ерөнхий аудиторын өгсөн дүгнэлтийг бүрэн эхээр нь цахимаар
	Аймаг, нийслэлийн Засаг даргаас аймаг, нийслэлийн ИТХ-д өргөн мэдүүлсэн дараа жилийн төсвийн төсөл	Сангийн сайдын 2012 оны 244-р тушаал, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2-р хавсралт
Жил бүрийн 12-р сарын 5-ны дотор	Аймаг, нийслэлийн дараа жилийн төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал	Жил бүрийн 12-р сарын 5-наас өмнө хуралдсан байдлаар
Жил бүрийн 12-р сарын 10-ны дотор	Сум, лүүргийн Засаг даргаас сум, дүүргийн ИТХ-д өргөн мэдүүлсэн дараа жилийн төсвийн төсөл	Сангийн сайдын 2012 оны 244-р тушаал, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2-р хавсралт
Жил бүрийн 12-р сарын 20-ны дотор	Сум, дүүргийн дараа жилийн төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал	Жил бүрийн 12-р сарын 20-ноос өмнө хуралдсан байдлаар
Жил бүрийн 12-р сарын 31-ний дотор	Дараа оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь	Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн сар, улирлын хуваарийн маягтаар
1, 4, 7, 10-р сарын 20-ны дотор (Жилд 4 удаа)	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын улирал бүрийн нөөц хөрөнгийн ил тод байдал	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн маягтаар

Жилийн турш (батлагдсанаас хойш 7 хоногийн дотор)	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.3, 1, 2, 20-р хавсралт (цахим)
Жилийн турш (үнэлгээний хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор)	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.6, 7-р хавсралт (цахим)
Жилийн турш (шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор)	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээ (гэрээ, хэлцэл хийсэн, санхүүжилт өгснөөс хойш)	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.9, 8-р хавсралт (цахим)
Жилийн турш (гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор)	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хамт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.10 9-р хавсралт (цахим)
Жилийн турш (шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор)	Зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн тухай шийдвэр	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.7, 10-р хавсралт (цахим, PDF форматаар)
Жилийн турш (дүн гарснаас хойш 7 хоногийн дотор)	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.13 (цахим, PDF форматаар)
Тодотгол хийсэн тухай бүр	Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн тодотгол (хэрвээ тодотгол хийгдсэн бол)	Тодотгол хийсэн бол тухай бүр


* Сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ-сар бүрийн мэдээг дараа сарын 8-ны дотор гаргана, улирал бүрийн сүүлийн сарын мэдээ нь улирлын, 6-р сарын мэдээ хагас жилийн, 12-р сарын мэдээ бүтэн жилийн мэдээ байдлаар гарна гэсэн үг.

2.5. Орон нутгийн төсвийг хянаж, үнэлэх үе шат

Төсвийн хяналтын зорилго нь орон нутаг, байгууллага батлагдсан төсвийг дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу, хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байгаа эсэхийг шалгаж тодруулахад чиглэнэ.

Төсвийн хяналтыг гадаад болон дотоод хяналт гэж ангилна.

Зураг 3. Төсвийн хяналтын хэлбэрүүд



Дотоод хяналтыг төсвийн шууд захирагч буюу байгууллагын дарга, төсвийн ерөнхийлөн захирагч буюу тухайн шатны болон дээд шатны Засаг дарга, Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжээс гүйцэтгэнэ. Харин гадаад хяналтыг Төрийн аудитын байгууллага, ИТХ, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага, иргэд гүйцэтгэнэ.

Засгийн газар Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6.4-т заасныг үндэслэн 2011 онд 311 дүгээр тогтоол гаргаж, “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг баталсан.

Төсвийн тухай хуулийн “Хяналт, шалгалт” гэсэн 10 дугаар бүлгийн “Дотоод аудит” гэсэн 69 дүгээр зүйлд “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтийн явц байдалд үнэлэлт, дүгнэлт өгч эрсдлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитыг хэрэгжүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитыг арга зүйгээр хангана. Дотоод аудитын дүрмийг Засгийн газар батална” гэжээ. Ийнхүү Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”-ийг, Сангийн сайдын **2013 оны 29 дүгээр** тушаалаар “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг батлан гаргаж, бүх шатны төсвийн захирагч нар дагаж мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын дүрмээр Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт болон дотоод аудитын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтарч ажиллах зэрэг харилцааг зохицуулдаг. *Дотоод аудитын үйл ажиллагааны зорилго* нь төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Дотоод хяналт ба дотоод аудитын ялгааг дараах хүснэгтэд харьцуулан харууллаа.

Хүснэгт 9. Дотоод хяналт ба дотоод аудитын ялгаа

Ялгагдах шинж	Дотоод хяналт	Дотоод аудит
Хийх субъект	НББ, хууль, эдийн засаг гэх мэт байгууллагын дотоод нэгж, хэсгийн мэргэжилтнүүд хийдэг	Дотоод аудитын болон дотоод хяналтын ажилтнууд хийдэг
Зорилго	Үйл ажиллагааг үр ашигтай явуулах тасралтгүй хяналтыг эдийн засгийн субъект дээр хэрэгжүүлдэг	Байгууллагын нэгж хэсгийн ажлын чанарын хяналт, дотоод хяналтын системийн үнэлгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ
Эрхийн статус	Холбогдох аж ахуйн нэгж, албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагын тухай журмыг баримтална	Дотоод аудитын албаны журмыг удирдлага болгож ТЕЗ-д ажлаа тайлагнана
Хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх технологи	Захиргаа, НББ, эдийн засгийн хяналтын арга, технологийг ашиглана	Урьдчилсан төлөвлөгөө, эрсдлийн үнэлгээ, хяналт шалгалтын үнэлгээ, аудитын хөтөлбөр боловсруулах, аудит хийх арга, баримтжуулалт зэрэг аудитын стандарт тусгай аргыг ашигладаг

Эх сурвалж: Майнбаяр Б. (2011). Дотоод аудит ба дотоод хяналт (COSO), тэдгээрийн ялгаатай талууд. Дэлхийн банк. Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл. Улаанбаатар.

Дотоод хяналтын зорилго нь төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагаа гэж тодорхойлогдож байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, зөрчлийг тайлагнахаас илүүтэй байгууллагад учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сул талыг сайжруулах чиглэлтэй хэрэгжинэ. Хяналтыг явуулахдаа төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг тайлагнах болон хяналтаас гарсан зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээ гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэнэ.

Төсвийн гадаад хяналтыг аймаг, нийслэлийн төрийн аудитын газар тавихаас гадна тухайн орон нутгийн ИТХ болон иргэдийн зүгээс тавих хяналт орж байдаг. Тухайн жилийн орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг хянах бүрэн эрх тухайн шатны ИТХ-д хуулиар олгогдсон бүрэн эрх юм.

ГУРАВ. УЛС, САЛБАР, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ БА ТӨСВИЙН УЯЛДАА

3.1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн тухай ойлголт

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай" хууль 2020 оны 5-р сард батлагдан хэрэгжиж эхлээд байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий дараах гурван төрөлтэй байна. Үүнд:

- урт хугацааны 30 хүртэл жил
- дунд хугацааны 5-10 жил
- богино хугацааны 1-4 жил

30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх *Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг* нь дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн үндэс байна.

Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дараах "Хөгжлийн зорилтот хөтөлбөр"-үүд байна. Үүнд:

- 1) Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 2) Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 3) Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 4) Байгаль орчны зорилтот хөтөлбөр;
- 5) Засаглалын зорилтот хөтөлбөр;
- 6) Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 7) Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр хамаарна.

Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь:

- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцсэн, түүнд тусгасан арга хэмжээг аймаг, нийслэл, хотын түвшинд хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;
- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээг орон нутгийн онцлогийг харгалзан нарийвчлан төлөвлөсөн, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх тухайн таван жилд хэрэгжүүлэх эрэмбэ дараалал бүхий арга хэмжээ байх;
- Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөтөлбөрийг хавсаргах шаардлагатай.

Богино хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

- Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг сонгон боловсруулсан байх;
- Хөгжлийн зорилтот хөтөлбөрт заасан төсөл, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;
- Тухайн орон нутгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн улсын, бүсийн болон орон нутгийн хөгжлийн зорилтуудтай уялдсан байх;
- Зорилт, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх;
- Бүс нутгийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж, харилцан уялдаатай хөгжих боломжийг хангасан байх.

Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт:

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв
- Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөв хамаарна.

Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна:

- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх;
- Санхүүжилтийн баталгаат эх үүсвэртэй, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан тухайн жилд хэрэгжих төсөл, арга хэмжээний задаргаа байх;
- Улсын төсөв нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;
- Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн захиргааны байгууллагууд болон нэгжийн чиг үүргийг эрхлэн гүйцэтгэгчид, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийн хуулийн этгээд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцоно.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүрэг

Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан эсэх талаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг харгалзан тухайн бодлогын баримт бичгийг хэлэлцэн, батлах, эсвэл буцаах үүрэгтэй.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүрэг

- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулахад холбогдох саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газар болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлэх;
- Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

3.2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тавигдах шаардлага, цаглабар

Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахдаа бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинд үндэслэн үйл ажиллагаа, бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, бодлогын баримт бичигт хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгасан байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба эцэслэсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ.

Хүснэгт 10. Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах цаглабар

Баримт бичгийн нэр	Байгууллага, албан тушаалтан	Боловсруулах, батлах хугацаа
Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд суурилсан Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөл	Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл, хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан захиргааны байгууллагатай хамтран	Өмнөх төлөвлөгөөний баримт бичиг дуусгавар болохоос нэг жилийн өмнө боловсруулна.
Аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөл	Аймаг, нийслэлийн ИТХ үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан	Үйлчлэх хугацаанаас 6 сарын өмнө батална.
Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ИТХ-д	Хууль тогтоомжид заасан хугацаанд танилцуулна.

Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Аймаг, нийслэлийн Засаг дарга үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авч	Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.
Сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн саналыг авч	Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.
Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ	Засаг даргыг томилогдсоны дараах 45 хоногт багтаан батална.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батлан хэрэгжүүлнэ.

3.3. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний цаглабар

Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ба Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь *Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор* боловсруулна.

Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт болон дараа жилийн төлөвлөгөөний төслийг *жил бүрийн 5 дугаар сарын 25-нд* багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, УИХ *7 сарын 1-ний дотор* батална.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт болон дараа жилийн төслийг *9 дүгээр сарын 01-ний дотор* боловсруулж, аймаг, нийслэлийн ИТХ Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг *жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор* батална.

Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилт нь дараах эх үүсвэртэй байна.

- Улсын болон орон нутгийн төсөв;
- Гадаадын зээл, тусламж;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас;
- Концессын гэрээ;
- Бусад эх үүсвэр.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 20.2 дахь заалт

Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн батлагдсан баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна. “Алсын хараа 2050” Монгол улсын хөгжлийн урт хугацааны хөгжлийн бодлогыг УИХ-ын 2020 оны 5 сарын 52 дугаар тогтоолоор баталж, 3 үе шаттай хэрэгжүүлэхээр тодорхойлсон.

- *I үе шат (2021-2030):* Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлэх үе.
- *II үе шат (2031-2040):* Үндэсний бахархлыг иргэн бүрийн үйл хэрэгт шингээж, түүнд тулгуурласан үндэсний эв нэгдлийг төлөвшүүлэх үе.
- *III үе шат (2041-2050):* Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшиж, эв нэгдэл нягтрах үе.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан.

Шинээр байгуулагдсан Засгийн газар нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн УИХ-ын 2020 оны сонгуульд оролцсон Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тулгуурлан нам, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналуудад үндэслэн 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж, зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Эдгээр үндэсний хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгүүд батлагдсанаар үндэсний болон орон нутгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлого нь үр дүнд суурилсан удирдлагын хүрээнд хэрэгжих бөгөөд бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нь харилцан уялдаатай, нэгдмэл зорилго, зорилтод чиглэсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн шинэ орчин бүрдэж, нэгдсэн бодлогоор улс орныг хөгжүүлэх боломж бүрдсэн юм. Иймээс аймаг, нийслэл хотыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөө нь үндэсний хэмжээнд тодорхойлсон бодлого, төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэх, орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжилтийг хангахад төсвийг чиглүүлэх шаардлагыг бий болгож байна.

ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ШИЙДВЭР ГАРГАЛТ, ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ

4.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвлөлт

Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах гол арга хэрэгсэл нь төсвийн хөрөнгө оруулалт юм. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт нь зөвхөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хязгаарлагдахгүй.

Орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалт нь:

- 1) Улсын төсвийн санхүүжилтээр аймаг, нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалт
- 2) Улсын төсвийн санхүүжилтээр сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт
- 3) Аймаг, нийслэлийн төсвөөр аймаг, нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалт
- 4) Аймаг, нийслэлийн төсвөөр сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт
- 5) Сум, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
- 6) Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт
- 7) Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт
- 8) Сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт
- 9) Зээл, хандив, тусламжаар аймаг, нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалт
- 10) Зээл, хандив, тусламжаар сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт гэх мэтээр ангилагдаж болно.

Иймд дээрх орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийг уялдуулах, үр ашигтай байдлыг хангах шаардлага тавигдана.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө дараах асуудлуудыг нягтлан үзсэн байхыг шаарддаг. Үүнд:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачаалал бий болох эсэх дүгнэлтийг гаргасан байх;
2. Хөрөнгө оруулалтын арга хэмжээ нь эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой нь урьдчилсан судалгаагаар нотлогдсон байх;
3. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад тухайлбал, газрын зөвшөөрөл болон инженерийн шугамд холбох зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгах;
4. Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байгаа эсэхийг нягтлах;
5. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг нь тодорхойгүй арга хэмжээ тусгагдсан эсэх.

Тухайлбал, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр барьсан зарим барилга, байгууламжийн ашиглалтын зардлыг хэрхэн шийдвэрлэх вэ? гэдэг асуудал барилгыг баригдсаны дараа яригдахгүй, төсөв нь

тусгагдаж хэрэгжихээс өмнө шийдвэрлэгдсэн байхыг хуулиар зохицуулж өгсөн. Мөн зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл батлагдаад тухайн жилдээ зураг төсвийг нь хийгээд ажил нь эхэлсэнгүй, зураг төсөв хийгдсэний дараа төсөвт өртөг нь дутаад тендер шалгаруулалт зарлагдсангүй, эсвэл олон жил дамжаад төсөв дутсан гэдэг асуудал хуулиа дагаж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд яригдах боломжгүй болох нь харагдаж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүжүүлэх хяналт тавих, тайлагнах үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 29 дугаар зүйл, Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ыг баримтална.

Сангийн яам болон **тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг** дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана:

- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах;
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах;
- Нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;
- Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;
- Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

Төсвийн тухай хуулийн 29.3 дахь заалт

Төсвийн тухай Монгол Улсын хуульд хөрөнгө оруулалтын төсвийг хэрхэн боловсруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг жилийн төсвийн төсөлд хэрхэн тусгахыг дараах байдлаар нарийвчлан зохицуулжээ.

Нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад тусгахыг хуулиар хориглосон байна. Харин энэ чиглэлээр гаргах хөрөнгийн зардлыг орон нутгийн төсвийн суурь зарлагад дараах байдлаар тусган хянуулж тооцохоор журамлажээ. Үүнд:

- Өөрийн хэрэгцээнд албан конторын барилга худалдаж авах, эсвэл шинээр барих бол өмнөх барилгын ашиглалтын хэрэгцээ хангахгүй болсныг нотолсон мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- Шинээр барих барилгын зураг төсөв, техникийн бусад зөвшөөрөл;
- Их засвар хийхээр бол холбогдох төсвийг зохих норм, норматив, дүрмийн дагуу бэлтгэсэн байх;
- Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдаж авахаар бол өмнө нь ашиглаж байсан хөрөнгө нь зохих элэгдлийн нормд заасны дагуу өртгөө бүрэн нөхсөн, эсвэл зохих журмын дагуу хэрэглээнээс актлагдсан бол орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлээс хасагдсаныг нотолсон байх;
- Албан хэрэгцээний автомашин авах бол зөвхөн шинэ автомашин худалдан авахаар тооцох;
- Шинэ хөрөнгө оруулалттай холбоотой урсгал зардлын хэмжээг тооцсон байх шаардлагатай.

Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, орон нутгийн төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг тусламжаар бий болсон хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэнэ. Мөн

төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдтэй хамтарч хөрөнгө оруулсан бол төсвөөс санхүүжүүлсэн хувь хөрөнгийн хэмжээгээр орон нутгийн өмчид хамааруулна.

4.2. Орон нутгийн хөгжлийн сан, түүний төлөвлөлт, шийдвэр гаргалт, хэрэгжилт, хяналт

Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцлийн бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг нь Засгийн газраас орон нутгийг хөгжүүлэх зорилгоор өгч буй дэмжлэг бөгөөд гол онцлог нь орон нутаг иргэдтэйгээ хамтран тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэхэд чиглэнэ.

ОНХС нь иргэдийн оролцоотой төлөвлөлт, төслийн үнэлгээ эрэмбэлэлт, хэрэгжилт болон худалдан авах ажиллагаа, хяналт-шинжилгээ үнэлгээ, хөрөнгийн удирдлага гэсэн үндсэн 5 үе шатыг хамран зохион байгуулагддаг. Үе шат бүрд иргэд оролцох, мэдээллээр хангагдах, хяналт-шинжилгээ хийх боломж бий.

Төсвийн тухай хуульд ОНХС-ийн үйл ажиллагааны зохицуулалт тусгалаа олсноос хойш 21 аймаг, 330 сум, нийслэл, түүний 9 дүүрэгт хэрэгжиж ирлээ. Уг сан нь орон нутгийн онцлогт тохируулан орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдэд мэдээлэл хүргэх, олон нийтийн санал авах, иргэдийн оролцоотойгоор тулгамдсан асуудлыг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээг боловсруулах, төслийн жагсаалт боловсруулах, төслийг хэлэлцэх, саналыг эрэмбэлэн шийдвэр гаргах, төслийн хэрэгжилтийг хангах, хянаж үнэлэх, ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгдсэн үйл явц юм.

ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хуваарилах, төлөвлөх, гүйцэтгэлийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах үйл явцыг дараах хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.

Хүснэгт 11. ОНХС-ийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актууд

Эрх зүйн актын нэр	Батлагдсан он
Төсвийн тухай хууль	2011
Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	2020
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	2006
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	1996
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	2005
Төрийн аудитын тухай хууль	2020
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	2015
Төрийн хяналт шалгалтын тухай хууль	2003
Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам	МУЗГ-ын 2017 оны 89-р тогтоол
Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам	Сангийн сайдын 2018 оны 228-р тушаал
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал	Сангийн сайдын 2016 оны 17-р тушаал
Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам	Сангийн сайдын 2013 оны 39-р тушаал
Төрийн сангийн үйл ажиллагааны журам	МУЗГ -ын 2015 оны 24-р тогтоол

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал	МУЗГ-ын 2017 оны 230-р тогтоол
Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам	Сангийн сайдын 2019 оны 290-р тушаал

Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсад 2013 онд анх удаа “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”-г бий болгож, уг сангаас хуульд заасан дөрвөн итгэлцүүрт үндэслэн аймаг, нийслэлд орлогын шилжүүлэг олгох, аймаг, нийслэл нь мөн аргачлалын дагуу харьяалагдах сум, дүүргийн ОНХС-д хөрөнгө хуваарилдаг.

“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ.

Төсвийн тухай хуулийн 4.1.28 дахь заалт

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- a) Импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний НӨАТ-ын татварын 5 хувь;
- b) Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь;
- c) Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;
- d) Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

Түүнчлэн ОНХНС-аас *ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутагт хуваарилахдаа* ашигт малтмалын олборлолт хийгдсэн тухайн орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээг бусад орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээнээс 10 хүртэл хувиар нэмэгдүүлэн тогтооно. Хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг *тусгайлан заасан тохиолдолд* тухайн ОНХС-д шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй байх хуулийн зохицуулалттай.

Төсвийн тухай хуулиар ОНХНС-ийн хөрөнгийг аймаг, нийслэлд дараах итгэлцүүрийг үндэслэн хуваарилдаг. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн индекс;
- Хүн амын тоо;
- Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;
- Орон нутгийн татварын идэвх санаачилга гэсэн итгэлцүүр хамаарна.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий ОНХС-тай байна. Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 1) Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
- 2) Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;
- 3) Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.
- 4) Ашигт малтмалын тухай хуульд заасан үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалаас бусад АМНАТ-ын орлогоос улсын чанартай томоохон төсөл арга

хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн АМНАТ-ын төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувийг тухайн аймаг, нийслэлийн ОНХС-д хуваарилна.

- 5) Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.

Төсвийн хуулийн өөрчлөлтөөр ОНХНС-аас зарим суурь зардлыг санхүүжүүлдэг болсон юм.

Энэхүү өөрчлөлтөөр орон нутгийн чиг үүрэгт багтаж буй дараах зардлыг тухайн орон нутгийн ОНХС-д хуваарилан санхүүжүүлж байна. Тухайлбал:

- Нийслэлийн усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламжийг бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх, мал амьтны халдварт шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавьжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;
- Аймгийн хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх мал амьтны халдварт шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавьжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах;
- Дүүргийн нутаг дэвсгэрт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал амьтны халдварт шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавьжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх,
- Сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх, мал амьтны халдварт шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавьжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт үзүүлэх, сумын хэмжээнд орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг тухайн орон нутгийн ОНХС-д хуваарилан санхүүжүүлж байна.

ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох нарийвчилсан аргачлалыг “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал батлах тухай” Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Аймаг, нийслэлээс ОНХНС-ийн хөрөнгийг сум, дүүрэгт хуваарилахдаа энэхүү тогтоолын дагуу тухайн сум, дүүргийн хүн ам, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэслэн хуваарилдаг. Төсвийн тухай хуулийн дагуу дээрх суурь үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум, дүүргийн ОНХС-д шилжүүлэх бөгөөд эдгээр арга хэмжээг төлөвлөхөд иргэдийн санал авахгүй байхаар зохицуулсан байна.

ОНХНС бий болсноос хойш аймаг, нийслэлд олгосон ОНХНС-ийн шилжүүлгийн орлогын 70-аас доошгүй хувийг сум, дүүрэгт хуваарилж байсан бол Төсвийн тухай хуульд 2017 онд орсон өөрчлөлтийн дагуу ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлгээс дээр дурдсан суурь үйлчилгээний зардалд ногдох хэсгийг хасч, үлдэх хэсгийн 30-аас доошгүй хувийг суманд хуваарилж байна.

Монгол Улсын Засгийн газар, “Олон улсын хөгжлийн ассоциаци”-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу 2015 оноос “Тогтвортой амьжиргаа-3” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн гол зорилго нь хөдөө орон нутагт засаглалыг бэхжүүлж, иргэдийн оролцоотой тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх юм. ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх болон хяналт тавих чиглэлээр төслөөс орон нутгийн удирдлага, захиргааны байгууллага болон иргэд, олон нийтэд сургалт зохион байгуулж, техникийн тусламж дэмжлэг үзүүлж байна.

ОНХС-ийн үйл ажиллагаанд “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ” хийж, тодорхой болзол хангасан сумдад ОНХС-ийн санхүүжилтийн 25%-тай тэмцэх хэмжээний “урамшуулал”-ыг 2017 оноос жил бүр олгож байна. Үнэлгээний шалгуур үзүүлэлт нь ОНХС-г хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, дүрэм, журмын хүрээнд сумдын засаглалыг хэд хэдэн бүлэг үзүүлэлтээр тодорхойлдог. Үнэлгээний үр дүнд сумдад олгох урамшууллыг орон нутгийн төсөвт тусгадаг. Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийсэн эхний жил буюу 2016 онд нийт 330 сумын дундаж оноо 32% байсан бол 2017 онд 37%, 2018 онд 50%, 2019 онд 59.5%-д хүрээд байна. 2020 онд Тогтвортой амьжиргаа төслөөс 248 суманд 6.5 тэрбум төгрөгийн урамшуулал, 330 суманд 3.5 тэрбум төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:

- Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ;
- Улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;
- Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;
- Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;
- Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;
- Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” батлагдсан бөгөөд орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаанд энэ журмыг баримтална.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг төлөвлөлтийн үе шат, гүйцэтгэлийн үе шат, тайлагналын гэсэн үе шат гэсэн 3 үе шатанд хуваадаг.

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт

Төлөвлөлтийн үе шатанд иргэд баг, хорооны Засаг даргад саналаа гаргахаас эхлэн баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал (ИНХ) иргэдээс гарсан саналуудыг эрэмбэлж, сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэгт хүргэх, ажлын хэсэг саналуудыг нэгтгэн эрэмбэлж сум, дүүргийн Засаг дарга, Засаг даргын зөвлөлд танилцуулах, сум, дүүргийн Засаг дарга нэгдсэн жагсаалтыг сум, дүүргийн ИТХ-д өргөн барих хүртэлх үйл ажиллагаа хамаарна.

ОНХС бол иргэдийн бодит хэрэгцээнд тулгуурласан хөрөнгө оруулалтыг хийх зорилготой сан юм. Иймээс жил бүр иргэдээсээ саналыг нь сонсож, тэдний амьдрах орчныг сайжруулахад шаардлагатай байгаа зүйлс, бодит хэрэгцээг нь тодорхойлохын тулд баг, хорооны Засаг дарга нараар дамжуулан саналыг нь авдаг. Аль болохоор олон

иргэн үр шимийг нь хүртэх боломжтой, дийлэнх олонхийн саналаар батлагдсан хөрөнгө оруулалт дэмжигдэх нөхцлийг хууль, тогтоомжид тусгасан байдаг. Орон нутгийн төсвийн багахан хэсгийг эзэлдэг ОНХС-ийн санхүүжилт нь иргэнийхээ хэрэгцээ, шаардлагад нийцсэн, тэдний саналаар гарсан хөрөнгө оруулалтуудад зарцуулагдах ёстой тул сум, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн дараа онд гүйцэтгэх хөрөнгө оруулалтын нэгдсэн жагсаалтыг ажлын хэсгээс ирүүлсэн саналын дагуу тухайн жилийн төсөвтөө багтаан батлах нь зүйтэй юм.

ОНХС-ийн төлөвлөлтөд багийн иргэдийн оролцоог хангах нь

Баг, хорооны Засаг дарга нь сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар (ЗДТГ)-тай хамтран өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, тухайн онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх дараа жилийн үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний танилцуулгын хамт бэлтгэж баг, хороо, сум, дүүргийн мэдээ, мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2 дугаар сард багтаан олон нийтэд танилцуулна.

Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулахдаа санал асуулгын хуудсаар, бүлгийн ярилцлага хэлбэрээр, мөн цахим хэлбэрээр зохион байгуулж болно. Баг, хорооны Засаг дарга нь иргэдээс санал авах ажлыг жил бүр зохион байгуулна.

- *Санал асуулгын хэлбэрээр* иргэдээс санал авахдаа орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 1-р хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн санд иргэдээс санал авах маягт”-ыг багийн өрх бүрд хүргүүлж, бүртгэл хөтлөнө. Ирүүлсэн саналыг журмын 2-р хавсралтад заасан маягтын дагуу нэгтгэнэ.
- *Бүлгийн ярилцлага хэлбэрээр* санал авах тохиолдолд 50-иас доошгүй (сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны хувьд 30-аас доошгүй) иргэний бүрэлдэхүүнтэй бүлгийн ярилцлага, хэлэлцүүлгийг бүлэг тус бүрт 2-оос доошгүй удаа зохион байгуулах ба хэлэлцүүлгийн үеэр иргэдээс авсан саналыг хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусган хэлэлцүүлэгт оролцсон иргэдийн гарын үсгээр баталгаажуулна.
- *Цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэрээр* санал авах тохиолдолд 30-аас доошгүй хоногийн турш тогтсон цахим хаяг, цахим хуудсаар саналыг хүлээн авч журамд заасан маягтын дагуу нэгтгэн баталгаажуулна.

Баг, хорооны Засаг дарга иргэдээс авсан саналыг нэгтгэн урьдчилсан жагсаалтыг гаргаж, танилцуулга мэдээллийн хамт баг, хорооны ИНХ-д оруулж хэлэлцүүлнэ. Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.10 дахь заалтын дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 5 дугаар сард багтаан зохион байгуулна.

Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 23.10 дахь заалт

Баг, хорооны ИНХ-ын дарга хурлын ирцийг бүртгэн оролцогчдоор гарын үсэг зуруулж, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж, ИНХ-ын Тэргүүлэгчдийн гарын үсгээр баталгаажуулна. Баг, хорооны Засаг дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн

хөрөнгөөр санхүүжүүлэх урьдчилсан жагсаалтад багтсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал нэг бүрийг ИНХ-д танилцуулна. Баг, хорооны ИНХ-ын дарга ийнхүү танилцуулсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал болон тухайн хурлын үеэр дэвшүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал тус бүрийг дэмжиж буй эсэхийг ил тод санал хурааж шийдвэрлэнэ.

Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг, санал өгсөн иргэдийн тоог баг, хорооны сонгуулийн насны иргэдийн нийт тоонд харьцуулсан харьцаагаар эрэмбэлсэн тэргүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг ИНХ-ын тогтоолоор батална. Эрэмбэлсэн саналын жагсаалтыг баг, хорооны ИНХ-ын тэмдэглэлд тусгана. ИНХ-ын тогтоол болон тогтоолоор батлагдсан саналын жагсаалтад тусгагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийн танилцуулгыг 5 дугаар сард багтаан сум, дүүргийн Засаг даргад албан бичгээр хүргүүлнэ.

Сум, дүүргийн түвшинд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг төлөвлөх

Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь орон нутгийн хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал хариуцсан ажилтан, төрийн сангийн мэргэжилтэн, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон бусад мэргэжилтнүүдийг багтаасан 7-оос доошгүй гишүүнтэй байна.

Ажлын хэсэг нь баг, хорооны ИНХ-аас ирүүлсэн тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг эрэмбэлэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг хэлэлцэж, дараагийн төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг *жил бүрийн 6 дугаар сард багтаан* боловсруулна.

Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ:

- Баг, хороодоос ирүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь баг, хорооны иргэдийн олонхийн саналаар дэмжигдсэн эсэх;
- Сум, дүүргийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан эсэх зэрэг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу холбогдох үзүүлэлтийг харгалзан зөвлөмж дүгнэлт гаргаж сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.

Сум, дүүргийн Засаг дарга нь баг, хорооны ИНХ-ын баталсан жагсаалтад багтсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй бол тухайн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг тусад нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж болно.

Сум, дүүргийн Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг тухайн шатны ИТХ-д төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ.

ИТХ нь өргөн мэдүүлсэн жагсаалтад тусгагдсан асуудал нь хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан эсэх, зураг төсөв нь хийгдсэн эсэх, иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн байдал зэрэг хууль тогтоомжид нийцсэн байдлыг хянаж батална.

Сум, дүүргийн Засаг дарга нь ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн өгсөн санал багтсан болон багтаагүй шалтгааныг тухайн саналыг ирүүлсэн баг, хорооны Засаг даргаар дамжуулан иргэдэд заавал мэдээлнэ.

Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

Ажлын хэсэг аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг дараах үзүүлэлтүүдийг харгалзан боловсруулна. Үүнд:

- 1) Тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого, чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөө;
- 2) Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ;
- 3) Өмнөх төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ;

Аймаг, нийслэл нь ОНХНС-аас хуваарилсан хөрөнгөөс аймаг, нийслэлд үлдэх хэсэг болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд сум, дүүргийн иргэдээс санал авах зорилгоор журамд заасан санал асуулгын хуудсанд тусгуулан баг, хорооны иргэдээс санал авах үйл ажиллагаатай хамтад нь жил бүр зохион байгуулж болно. Ажлын хэсэг нь сум, дүүргийн иргэд, ЗДТГ-аас ирүүлсэн саналыг урьдчилсан жагсаалтад нэмж тусган хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг нэгтгэнэ.

Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 7 дугаар сард багтаан 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хамгийн олон санал авсан, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэгдсэн жагсаалтыг хурлын тэмдэглэл болон орон нутгийн төсвийн төсөлд тусган аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн ИТХ нь аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн саналыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн журмын 8 дугаар хавсралтад заасан дараах маягтын дагуу батална.

..... аймаг/нийслэлийн сум/дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт

(мян.төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дугаар	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	20... онд санхүүжих дүн
1.	Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	I			$I=2+...3$
	1.1. Төсөл, арга хэмжээ 1	2			
	1.2. Төсөл, арга хэмжээ 2	3			
2.	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	II			$II=...4+...+6$
	2.1. Төсөл, арга хэмжээ 1	4			
	2.2. Төсөл, арга хэмжээ 2	5			
	2.3. Төсөл, арга хэмжээ 3	6			
3.	ОНХС-аас санхүүжих суурь зардал. Үүнээс:	III			$III=7+8+9+...$
	3.1. Хот тохижилтын гэрэлтүүлэг, засвар үйлчилгээ	7			
	3.2. Мал эмнэлгийн үйлчилгээ	8			
	3.3. Усан хангамжийн татаас	9			
4.	Сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	IV			$IV=10+...$
5.	Сум, дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн дүн [1]	10			
6.	НИЙТ	11			$11=I+II+IV$

Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” болон түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалыг дагаж мөрдөнө.

Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймаг, нийслэлийн түвшинд, сум дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг сум, дүүргийн түвшинд зохион байгуулна.

Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хорин сая хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу иргэдийг оролцуулан зохион байгуулж болно. Үүнд:

- Сумын нутаг дэвсгэр дэх нийтийн ариун цэвэр, гудамж талбайн цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх;
- Хортон шавжийн устгал, хяналт;
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах
- Сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх

- Сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, арчлах зэрэг тусгай зөвшөөрөл шаардахгүй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт хамаарна.

Олон нийтийн оролцоотой хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байна. Сум, дүүргийн төсвийн хүрээнд олон нийтийн оролцоотой зохион байгуулагдах худалдан авах ажиллагаанд оролцохыг хүссэн иргэд Иргэний хуулийн дагуу хамтран ажиллах гэрээ байгуулж, сум, дүүргийн ЗДТГ-т хүсэлтээ гаргана.

ЗДТГ нь ирүүлсэн хүсэлтэд үндэслэн "Иргэдийн бүлгийн жагсаалт"-ыг бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан иргэдэд нээлттэй байлгана. Жагсаалтад багтсан гурав болон түүнээс дээш бүлэгт үнийн санал авах урилгыг албан бичгээр, цахим шуудангаар хүргүүлэн товлосон хугацаанд хүлээн авч, үнийн саналын нээлт хийж, харьцуулалтын аргаар шалгаруулна. Олон нийтийн оролцоотой бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад Сангийн сайдын 2012 оны 02 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан "Журам, жишиг баримт бичиг батлах тухай" 39 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны жишиг баримт бичиг"-ийг хэрэглэнэ.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно.

Төрийн сан дахь ОНХС-ын данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад *аймаг, нийслэлийн хувьд* 1 дүгээр гарын үсгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч, *сум, дүүргийн хувьд* 1 дүгээр гарын үсгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг ЗДТГ-ын ахлах нягтлан бодогч тус тус зурна. ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй бол төсвөөс санхүүжилт олгохгүй. ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ.

Сум, дүүргийн ЗДТГ-ын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж, дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Сангийн яамны ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст хүргүүлнэ.

ОНХС-ийн орлого, зарлага нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд ОНХС-ийн төсвийн

гүйцэтгэлийг тухайн аймаг, нийслэлийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэнэ.

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хяналт, ил тод байдал

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлнэ.

ИТХ нь хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Орон нутгийн хөгжлийн сан болон улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсэг байгуулан явцын хяналтыг гүйцэтгэн зөвлөмж, дүгнэлт өгч гүйцэтгэлийг тооцон ажиллана.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, сум, дүүргийн ЗДТГ хүлээнэ.

ОНХС-ийн мэдээллийн ил тод байдал нь хяналтын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хамгийн чухал нөхцөл болдог. Иргэд мэдээлэлтэй байвал орон нутгийнхаа асуудлыг шийдвэрлэх үйл явцад идэвх санаачилгатай оролцох боломж бүрдэнэ. ОНХС-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилготой ОНХС-ийн удирдлага, мэдээллийн системийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 12. Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг ил тод болгох цаглабар

Мэдээлэл	Хариуцах	Хугацаа
Орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөв (сум, дүүрэг тус бүрээр)	Аймаг, нийслэлийн ХОХБТХ	Жил бүрийн 12-р сарын 10-ны дотор
ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт	Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар	Жил бүрийн 12-р сарын 25-ны дотор
Орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн сум, дүүргээр хуваарилан баталсан сар, улирлын хуваарь	Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс	Жил бүрийн 1-р сарын 10-ны дотор
ОНХС-ийн орлогын шилжүүлгийн сум, дүүргээр батлагдсан хуваарийг ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд бүртгэж, бүртгэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд олгосон санхүүжилт	Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс	Ажлын 2 өдөрт багтаан мэдээлнэ.

ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтын талаарх мэдээллийг ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг

арилгах хүртэл ОНХНС болон аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй.

ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төлбөр хийгдсэн тухай бүр ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд оруулна.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь аймаг, нийслэлийн, харин сум, дүүргийн ЗДТГ нь сум, дүүргийн ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой хийгдсэн аудит, хяналт шалгалтын тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлага болон бусад мэдээллийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан хагас, бүтэн жилээр мэдээлнэ. Орон нутгийн хөгжлийн сангийн цахим систем <http://onhs.mof.gov.mn/>-д нэвтэрч ОНХС-ийн хөрөнгийн хуваарилалт зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг авч хяналт тавих боломжтой.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна. ОНХС-ийн төсөв боловсруулах, батлах, зарцуулах, тайлагнах, бүртгэх, хяналт тавих, зохион байгуулахад хууль тогтоомж зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн удирдлага, хяналт

Жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдсан хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас сум бүрт хуваарилан олгосноор сум хөгжүүлэх зээлийн эргэлтийн сан бий болсон. Энэхүү сангийн үйл ажиллагааг зохицуулах "Сум хөгжүүлэх санг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам" Засгийн газрын 2016 онд 153 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдаж, тухайн журмын хүрээнд сангийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэр нь хөдөлмөр эрхлэлтийн сангаас олгосон эргэлтийн хөрөнгөөс гадна зээлийн хүү болон хугацаа хэтрүүлсэн зээлд ногдуулсан алданги, хандив тусламжийн орлогоос бүрддэг. Сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Сум хөгжүүлэх санг бүрдүүлэх, зарцуулах талаар *аймаг, сумын Засаг дарга* дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төрийн бодлоготой уялдуулан харьяалах нутаг дэвсгэртээ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;
- Аймгийн хэмжээнд сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн зохих журмын дагуу шийдвэрлэх;
- Аймгийн хэмжээнд сангаас олгосон зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, тайлан, мэдээг хянан баталгаажуулах, тэдгээрийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх;
- Харьяалах нутаг дэвсгэртээ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах зэрэг эрх, үүрэг хамаарна.

Сангийн үйл ажиллагааны талаар *сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал* дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Тухайн жилийн сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох;
- Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын ИТХ-ын Тэргүүлэгчээр ахлуулан ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтэн, төрийн бус байгууллага болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах;
- Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулан ЗДТГ-ын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийн төлөөлөл дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах;
- Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн зохих журмын дагуу шийдвэрлэх болон хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Сум хөгжүүлэх сангийн зээлийг суманд олгосноор орон нутагт санхүүгийн эрх мэдэл олгогдсон, арилжааны банкаар дамжуулахгүй олгож байгаа нь иргэдэд чирэгдэлгүй болсон, сумдын удирдлага жижиг дунд үйлвэрлэлийг дэмжих идэвх сайжирч, иргэдийн санал санаачлага нэмэгдсэн, иргэд бие биедээ хяналт тавих нөхцөл бүрдсэн зэрэг давуу талууд бий болсон хэдий ч олгогдсон эрх мэдлийг зөв хэрэгжүүлээгүй, ИТХ-аас тавих хяналт суларснаас зээлийн эргэн төлөлт удааширч чанаргүй зээлийн хэмжээ ихсэх хандлага бий болсон байна.

ТАВ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ, ӨМЧИЙН УДИРДЛАГАД ИТХ, ТҮҮНИЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

5.1. Орон нутгийн төсвийн талаарх ИТХ, Засаг даргын бүрэн эрх

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга нь орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төсвийн талаарх бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх;
- Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах;
- Төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийг сонсох.

Засаг даргын төсвийн талаарх бүрэн эрх

Бүх шатны Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны ИТХ-д тайлагнах;
- Орон нутаг дахь төсвийн байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;
- Холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчтай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж ажиллах;
- ИТХ баталсан орон нутгийн төсвийг хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэх;
- Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу улсын төсвийн байгууллагын төлөвлөсөн зардлыг зориулалтаар нь цаг хугацаанд нь, тасралтгүй бүрэн санхүүжүүлэх;
- Тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж, мөрдүүлэх;
- Тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах.

Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулах заалт тусгагдсан байдаг.

5.2. Орон нутгийн төсвийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, зардлын мэдээллийг шинжлэх нь

Монгол улсын Төсвийн тухай хуульд зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсвэл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг

үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийхээр заасан байна. Түүнчлэн жил бүрийн төсвийн төслийг ИТХ-д батлуулахаар өргөн барихдаа төсвийн гүйцэтгэлд хийсэн шинжилгээний тайлан болон тухайн жилийн төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн урьдчилсан тооцооллын хамт хүргүүлэхээр хуульчилсан.

Сангийн сайдын 2018 оны 295-р тушаалаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал” батлагдан хэрэгжиж байна. Энэ аргачлалд үндэслэн бид орон нутгийн төсвийн болон ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шинжилгээг хийж болох юм. Өөрөөр хэлбэл, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын Төлөөлөгч нь төсвийг хэлэлцэж батлах, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавихдаа дараах чиглэлээр тодорхой хэмжээнд шинжилгээ хийж, үнэлэлт өгөх чадварыг эзэмшсэн байх нь чухал юм. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийх
- Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох
- Төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг шинжлэх
- Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн ашиглалт, үр дүнг үнэлэх
- Төсвийн жендерийн мэдрэмжтэй байдлын шинжлэх
- Төсөв байгаль орчинд ээлтэй байгаа эсэхийг тогтоох
- Төсвийн зарлага хүүхдэд ээлтэй эсэхэд шинжилгээ хийх
- Төсөв ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй эсэхийг үнэлэх

Ийнхүү орон нутгийн төсвийг иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилт, урт болон дунд хугацааны төлөвлөлттэй уялдуулах, хамгийн гол нь нутгийн иргэдэд үр өгөөжөө өгөхөд чиглүүлэн зарцуулахад анхаарах хэрэгтэй.

Төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийх

- *Төсвийн орлогын гүйцэтгэлд хийх шинжилгээ:* Юуны өмнө төсвийн орлогын гүйцэтгэлд шинжилгээ хийнэ. Тухайлбал, төсвийн орлогын гүйцэтгэлийг орлогын нэр төрөл бүрээр батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулж, тасалдсан болон давж биелсэн орлогод анхаарлаа хандуулж, орлого тасалдсан, эсвэл давж биелсэн шалтгааныг тодруулна. Байгалийн болон нийгэм, эдийн засгийн давагдашгүй хүчин зүйл, төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэн, эсвэл хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулсан зэрэг шалтгаанууд байж болно. Зөвхөн тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулах нь хангалтгүй байвал өмнөх жилүүдийн мэдээлэлтэй харьцуулж дүн шинжилгээ хийх боломжтой.
- *Төсвийн зарлагын гүйцэтгэлд хийх шинжилгээ:* Төсвийн зарлагад шинжилгээ хийхдээ зардлыг бүлгийн дүнгээр, эсвэл зардлын нэр төрөл тус бүрээр хийж болно. Төсөв хэтэрсэн, хэмнэсэн шалтгааныг тодруулах, уг шалтгаан нь төсөв захирагч нарын үйл ажиллагаатай холбоотой эсэх, байгалийн болон нийгэм, эдийн засгийн давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн эсэх, төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэхийг тодруулна.
- *Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд шинжилгээ* хийхдээ хөрөнгө оруулалтын ажил тус бүрээр тендер, гүйцэтгэгчийг хэрхэн шалгаруулсан, ажлын үе шатны гүйцэтгэлд хэрхэн хяналт тавьсан, батлагдсан зураг, төсвийн дагуу чанартай гүйцэтгэсэн эсэх, хэрхэн санхүүжүүлсэн, мэргэжлийн байгууллагын зүгээс хяналт тавьсан эсэх, захиалагчийн хяналтад иргэдийн оролцоог хангасан эсэх гэх мэт асуудлыг авч үзнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох

Сангийн сайдын 2018 оны 295-р тушаалаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал” батлагдан хэрэгжиж байна. Энэ аргачлалд үндэслэн бид орон нутгийн төсвийн болон ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шинжилгээг хийж болох юм.

Төслийн эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг тооцохдоо зардал-үр ашгийн шинжилгээ, зардал-үр өгөөжийн шинжилгээ, хамгийн бага зардлын шинжилгээ гэсэн 3 аргыг ашиглаж байна. Төсвийн шинжилгээ нь үнэн зөв бодитой мэдээлэлд үндэслэсэн байх шаардлагатай.

- *Төсвийн зардал - үр ашгийн шинжилгээг* тухайн төслийн санхүү, эдийн засгийн үр ашгийг тооцож тогтсон жишиг үзүүлэлттэй харьцуулан хамгийн ашигтай төслийг тодорхойлж эрэмбэлэхэд ашиглана.
- *Зардал-үр өгөөжийн шинжилгээ* нь хязгаарлагдмал хөрөнгө нөөцөд тулгуурлан төслийн үр шимийг хүртэгчдэд хамгийн ихээр нөлөөлөх, хамгийн өндөр үр өгөөж, ач холбогдолтой, илүү үр дүн гаргах төслийг тодорхойлоход чиглэнэ.
- *Хамгийн бага зардлын шинжилгээг* нэгж ажил үйлчилгээнд ногдох зардлыг тооцож, ижил ажил, үйлчилгээ үзүүлэх төслүүдийг хооронд нь харьцуулж хамгийн бага зардлаар зорилт, үр дүнд хүрэх төслийг тодорхойлж, эрэмбэлэхэд ашиглана.

Жишээлбэл, багийн иргэдийн Нийтийн Хурлуудаас ирүүлсэн жагсаалтад “Худаг гаргах” гэсэн арга хэмжээ олон тусгагдсанаас Засаг дарга ОНХС-аар хэрэгжүүлэх ажлын жагсаалтад зөвхөн 1 багт худаг гаргах асуудлыг тусгасан байна. Энэ төлөвлөлт зөв эсэхийг тогтоохын тулд ИТХ-ын Төлөөлөгч тодорхой хэмжээнд шинжилгээ хийж үзэх хэрэгтэй бөгөөд хамгийн олон айл өрх, мал сүргээ усаар хангах, бэлчээр ашиглалтад нөлөөлөх байдал зэрэг олон асуудлыг харьцуулан шинжилж, үр өгөөжийг тооцон хамгийн өндөр үр өгөөж өгөх газарт худаг гаргахаар төлөвлөх нь зүйтэй.

Төсвийн шинжилгээнд үр ашиг, үр өгөөжийг тооцохоос гадна *жендерийн мэдрэмжтэй байдал, байгаль орчинд ээлтэй байдал, хүүхдэд ээлтэй байдал* зэрэгт шинжилгээ хийж, орон нутгийн бодлого төлөвлөлт, төсөвлөлтөд тусгах шаардлага бий болж байна. Тухайлбал, “Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-т жендерийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг бүх түвшинд хөгжүүлнэ гэж заасан байна. Иймээс орон нутгийн төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг зохион байгуулахад оролцогчид хөтөлбөр, үйлчилгээний үр шим хүртэгчдийг хүйсээр ангилсан байдлаар судалгаа хийж, дүгнэлт гаргах шаардлагатай болно.

Оролцоог хангасан, жендерийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт байна гэдэг нь хөрөнгө оруулалтын төсөлд оролцогч талуудыг тодорхойлж, тэдний эрх ашиг, санаа бодлыг төсөл боловсруулахаас эхлээд төслийг үнэлэх үйл ажиллагааг дуусгах хүртэлх үе шатуудад харгалзан үзэж, оролцоог нь хангах явдал юм. Иймд оролцогч талууд, ялангуяа хөрөнгө оруулалтын төслийн үр шимийг хүртэгч эмэгтэй, эрэгтэй, хүүхэд, насанд хүрсэн хүн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал бодол, оролцоог төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, хяналтын үе шат бүрт хангах шаардлагатай. ОНХС-ийн төлөвлөлтөд оролцож санал өгсөн иргэд, тэдний саналыг хэрхэн шийдвэрлэснийг дараах байдлаар шинжилж болох юм.

Хүснэгт 13. ОНХС-ийн зарим мэдээллийг хүйсээр ангилсан байдал

Агуулга	Хүйсээр ангилсан мэдээлэл	...-р баг	...-р баг
Саналын хуудас тараасан нийт өрх	Нийт өрхийн тоо		
	Үүнээс: Эрэгтэй өрхийн тэргүүнтэй		
	Эмэгтэй өрхийн тэргүүнтэй		
Санал өгсөн хүний тоо	Нийт хүний тоо		
	Эрэгтэй		
	Эмэгтэй		
Санал нь багийн ИНХ-аар дэмжигдсэн байдал	Нийт саналын тоо		
	Эрэгтэйчүүдийн гаргасан саналаас дэмжигдсэн		
	Эмэгтэйчүүдийн гаргасан саналаас дэмжигдсэн		
Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын хэсгээс дэмжигдсэн саналын жагсаалт	Нийт арга хэмжээний тоо		
	Эрэгтэйчүүдийн гаргасан саналаас дэмжигдсэн		
	Эмэгтэйчүүдийн гаргасан саналаас дэмжигдсэн		
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төсөл арга хэмжээ	Нийт батлагдсан арга хэмээ		
	Эрэгтэйчүүдийн гаргасан саналаас дэмжигдэж батлагдсан		
	Эмэгтэйчүүдийн гаргасан саналаас дэмжигдэж батлагдсан		

Төслийн үр шимийг хүртэгчид, худалдан авах ажиллагаанд оролцогчид, гүйцэтгэгчид, гүйцэтгэлийн чанарын талаарх сэтгэл ханамж зэрэг бүхий л үзүүлэлтийг хүйсээр тооцох боломжтой юм. Аймаг, сумын ИТХ-аас баталж байгаа бодлогын хэрэгжилтийн үр дүнг ч хүйсээр ангилж жендерийн дүн шинжилгээ хийж, сайжруулах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж болох юм. Жишээлбэл, аймгийн хэмжээнд “Хөл бөмбөгийн спортыг дэмжих хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлж байгаа гэж үзье. Хөтөлбөрийн үр шимийг хүртэгчдийн 90% нь эрэгтэйчүүд байна. Тэгвэл хүйсийн тэгш байдлыг хангахын тулд эмэгтэйчүүдэд зориулсан хувцас солих өрөөтэй болгох, сдортоор хичээллэх орчин нөхцөлийг бий болгох, эмэгтэй дасгалжуулагчтай болох, эмэгтэй тамирчдыг сурталчилах, урамшуулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай болно.

Мөн орон нутгийн төсвийн хэдэн хувь нь хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд зориулагдаж, ямар үр дүнд хүрсэн байгааг олон талаас нь шинжилж, дүгнэлт гарган бодлого төлөвлөлтдөө ашиглах боломжтой.

5.3. Орон нутгийн төсөвт ИТХ-аас тавих хяналт

ИТХ-аас хэрэгжүүлдэг үндсэн чиг үүргүүдийн нэг нь хяналтын чиг үүрэг юм. Хяналтын чиг үүргийн хүрээнд ИТХ нь гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хянах, батлан гаргасан дүрэм журам, төсөв нь төлөвлөсний дагуу хэрэгжиж байгаа эсэхийг ажлын хороод, Төлөөлөгчдөөрөө дамжуулан, эсвэл мэргэжлийн байгууллага, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хянаж шалгах үйл ажиллагаа явуулдаг.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ бүрэн эрхийнхээ дагуу төсвийн хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлж болно. Үүнд:

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөхдөө түүнд шаардлагатай төсвийг хянах

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төсөл, жилийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хэлэлцэн батлахдаа хяналт тавих
- Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн байдлыг хянах
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг хянах
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэлэлцэх, төлөвлөх үйл явц, хөрөнгийн зарцуулалт, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг хянан шинжилж, үнэлэх
- Орон нутгийн байгууллагуудын Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих гэх мэт.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсөв, санхүүгийн байдал, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, орон нутгийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, ил тод байдалд хяналт тавина. Хяналтыг хэрэгжүүлж, үнэлэлт дүгнэлт өгөхдөө дараах тайлан, мэдээллийг ашиглах боломжтой. Үүнд:

1. Төсвийн байгууллагын зорилго, зорилт хангагдсан эсэх;
2. Холбогдох хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байгаа байдал;
3. Жилийн төсвийн гүйцэтгэл болон төсвийн төлөвлөгөөнд аудитын байгууллагын гаргасан зөвлөмж, тайлан, түүний мөрөөр хэрэгжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн эсэх;
4. Байгууллагын хувьд жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний тайлан;
5. Байгууллагын шилэн дансны үйл ажиллагаа, шилэн дансны цахим хуудсанд тавигдсан мэдээлэл;
6. Орон нутгийн төсвийн сар, улирал, хагас жил болон жилийн тайлан гүйцэтгэлийн мэдээ, үүнд төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл орно.
7. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, Засаг даргын улсын төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайлан;
8. Орон нутгийн төсвийн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан;
9. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл тайланг үнэлэх;
10. ИТХ-ын тогтоолын хавсралтаар батлагдсан тухайн байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан;
11. Сум хөгжүүлэх сангийн зээлийн олголт, ашиглалт, үр дүн;
12. Төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагчдын дотоод хяналтын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээлэл хамаарна.

Эдгээр мэдээллийг ашиглан ИТХ-ын Төлөөлөгчид болон иргэний зөвлөл, иргэд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан төсвийн орлого бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн байдалд төлөвлөгөөт болон урьдчилсан хяналтыг ИТХ-аас хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Түүнчлэн тухайлсан нэг орлого, зарлагыг сонгож хяналтыг хэрэгжүүлж болно. Жишээлбэл, Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалт, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэл, шатахууны зарцуулалт гэх мэт.

Орон нутгийн төсөвт ИТХ-аас хяналт тавих, иргэдийн оролцоог хангах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын туршилага

ИТХ-аас тавих хяналтын чиглэлээр:

- ✓ Өвөрхангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 2014 оны 38-р тогтоолоор “Нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх журам”-ыг батлан мөрдүүлж байна¹. Үүний зэрэгцээ тус аймгийн ИТХ “Иргэдийг чадавхжуулах замаар хяналтыг нэмэгдүүлэх нь” тэтгэлгийн хүрээнд ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлтөд иргэдийн саналыг авах, эрэмбэлэх ажлыг сүүлийн 2 жил орон нутагтаа үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх замаар иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж² байна. Мөн аймгийн 19 сумаас орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас үнэлгээний хороонд иргэний төлөөллөө оролцуулж буй байдалд мониторинг хийдгээс гадна “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдэж байгаа бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих “Иргэний хяналт” багийн ажиллах журам”-ыг гарган эдгээр багууд ИТХ-ын хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу хуралтайгаа хамтран ажиллаж чадавхижин туршлагажиж байна.
- ✓ Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ИТХ, багийн ИНХ-ын дэргэд Хяналтын хороог 7 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй ажиллуулж³, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө, ОНХС-гийн хөрөнгө, төсвийн зарцуулалт, суманд хэрэгжиж байгаа тендер шалгаруулалтад оролцон шалгарсан компани, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны явц, үр дүн, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг болсон.
- ✓ Сүхбаатар аймгийн ИТХ нь “ОНХС-гийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд аймгийн ИТХ-аас хяналт тавих, санал зөвлөмжөөр хангах нь” гэсэн чиглэлээр тэтгэлэг авч ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, тайлагнах, хэрэгжилтэнд тавих хяналтад иргэд хэрхэн оролцох боломжтой талаар сургалт явуулж, Халзан, Асгат, Баруун-Урт, Уулбаян, Түмэнцогт сумд иргэдийн оролцоотой хяналтын зөвлөл байгуулан ажиллаж байна⁴. Мөн Уулбаян суманд Засаг даргын захирамжаар ОНХС-гаар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлаа сумын албан тушаалтнууд, ТАХ-дад хариуцуулан өгч эзэнжүүлжээ.
- ✓ Баян-Өлгий аймгийн ИТХ хяналтын чиг үүргээ иргэдтэйгээ хамтран⁵ хэрэгжүүлэхээр аймгийн хэмжээнд болон сумдад ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа болон хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын явц, үр дүнд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдөөр ахлуулж, сум бүрийг хуваарилан ажиллажээ.

¹ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 8-9 дэх тал

² УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 105-112 дахь тал.

³ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 9-11 дэх тал

⁴ УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 113-116 дахь тал.

⁵ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 34-36 дахь тал

- ✓ Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ИТХ ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд иргэдийн хяналтыг бий болгох зорилгоор “ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөл”-ийг иргэдийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс оролцуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан⁶ ажиллуулдаг болжээ.
- ✓ Дундговь аймгийн Дэрэн сумын ИТХ бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажилд иргэдийнхээ хяналт, оролцоог нэмэгдүүлэх⁷ чиглэлээр сумын ИТХ-ын дэргэд бодлогын 4 хороо байгуулан ажиллаж байна.
- ✓ Увс аймгийн ИТХ-ын эмэгтэй Төлөөлөгчид санал гаргаж эмэгтэй төлөөлөгчид болон багийн ИНХ, ИТХ-ын ажлын албаны хамтарсан ажлын хэсэг байгуулах шийдвэр гаргуулж Сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэл, ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнд хяналт хийсэн байна. Хяналт шалгалтын үр дүнд СХС-ийн дансанд 130.0 сая төгрөгийн хугацаа хэмэрсэн зээлийг төвлөрүүлж, ОНХС-аар хийгдсэн ажлын явц гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгч зөвлөн ажилласан байна.
- ✓ Завхан аймгийн ИТХ сумынхаа 445 цэгт хүрэх замын урт, маршрутыг тогтоон төрийн үйлчилгээг хүргэх нэгдсэн стандарттай болсон байна. Ингэснээр эмнэлгийн түргэн тусламж болон бусад төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх шатахууны зардалд хяналт тавих боломж бүрдэж, байгууллагуудын шатахууны зардлын зарцуулалт сайжирч төсвийн үр ашиг дээшилсэн байна.

Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:

- Архангай аймгийн Тариат сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 62-р тогтоолоор “Иргэн, айл өрхийн нийгмийн оролцоог үнэлж дүгнэх” журмыг баталж хэрэгжүүлсэн байна. Тухайн жилд иргэдийг оролцуулах олон нийтийн ажил шалгуур үзүүлэлтийг баталж самбарт байршуулан үзүүлэлт бүрийг 0-10 оноогоор дүгнэсэн ба нэг өрхөөс 2 ба түүнээс дээш төлөөлөл оролцсоноор бүтэн оноо олгох ба олон нийтийн эрх ашигт нийцсэн санал санаачилга гаргаж хэрэгжүүлсэн тохиолдолд нийт онооны 20 хувийг нэмэгдэл болгон олгож, баг бүрээс хамгийн өндөр оноо авсан 3 өрхийг шалгаруулж урамшуулсан байна. Багийн ИНХ-ын ирц 30 гаруй хувиар нэмэгдсэн байна.
- Завхан аймгийн ИТХ “Ард иргэдээ сонсье” аяныг 2019 онд 3 удаа зохион байгуулж 48000 иргэн хамрагдаж 23000 санал ирүүлсэн байна. Саналыг эрэмбэлэн ажил хэрэгч саналуудыг аймаг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв, төрийн байгууллагуудын жилийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна. Ингэснээр орон нутгийн хөгжил дэвшилтэй холбоотой санал хүсэлтээ хүргүүлэх боломж бүрдэж иргэдийн гаргасан санал хүсэлтэд тулгуурлан орон нутгийн бодлого тодорхойлогдох болсон нь иргэдийн амьдралд ойрхон байх, асуудлыг бодитой шийдвэрлэх, нэн тэргүүнд анхаарал хандуулах салбар чиглэлийг тодорхойлох боломжийг бүрдүүлсэн байна.

Хяналт-шинжилгээ нь мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийснээр цаашид авч хэрэгжүүлэх алхмыг тодорхойлох боломжийг олгодог бол үнэлгээ нь хэрэгжилтийг

⁶ УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 192-193 дахь тал.

⁷ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 92-94 дэх тал

үнэлэх, дүгнэх замаар төслийн хэрэгжилт, үр ашигтай байдалд үнэлгээ өгөх үйл ажиллагаа байдаг.

Орон нутгийн төсөвт санхүүгийн хяналтаас гадна гүйцэтгэлийн хяналт хийж болно. Гүйцэтгэлийн хяналт нь тогтмол бус нэг удаагийн шинж чанартай ба байгууллагын үйл ажиллагааны үр дүнд чиглэсэн байх ба байгууллага зорилго зорилтдоо хүрэхдээ төсвийн боломжит нөөцөө хэрхэн үр ашиг, хэмнэлттэй удирдаж байна гэдгийн үнэлж, дүгнэнэ. Тухайлбал, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөсөн зорилгоо хангасан эсэхэд дүн шинжилгээ хийж, үр дүнг тайлагнах ба төсвийн зарцуулалт буюу зарлага нь хэмнэлттэй үр ашигтай байж чадсан эсэхийг үнэлэх боломжтой.

Аймаг сумын ИТХ нь хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх жил, улирал, сарын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хянаж явах нь хяналтыг үр дүнд хүргэх ач холбогдолтой.

Худалдан авах ажиллагаанд иргэдийг оролцуулах замаар ИТХ-аас хяналт тавихад анхаарах асуудал

Төсвийн тухай хуулиар төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно гэж заасан байна. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журамд төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй ажлын санхүүжилт, түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар төсвийн эрх захирагч, тухайн орон нутгийн захиргааны байгууллагаас орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудыг хөндлөнгийн хяналт тавих боломжоор хангах үүрэгтэй тусгажээ.

Хэрэв орон нутагт хэрэгжиж байгаа төсвийн хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой асуудлаар иргэд гомдол гаргавал нутгийн захиргааны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжгүй бол холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч, хяналт шалгалтын мэргэжлийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх боломжтой байна.

Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификатын сургалтыг Сангийн яамнаас олгосон зөвшөөрлийн дагуу хэд хэдэн сургалтын байгууллага явуулж байна. Сургалт нь худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн агуулгыг бүрэн илэрхийлсэн сургалтын 24 цагийн багтаамжтай, лекц, ярилцлага, хэлэлцүүлэг, дасгал, сорил хосолсон байдлаар явагддаг. Энэхүү сургалтанд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төслийн гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ИТХ-аас санал болгон оруулах боломжтой иргэд хамрагдаж АЗ сертификат авах тохиолдолд иргэд, иргэний нийгэм, ИТХ-ыг төлөөлөн хяналт тавьж оролцох боломжтой болно. ИТХ-аар батлагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжилт, худалдан авах ажиллагааны явцад иргэд, ИТХ-ын төлөөлөгчдийн зүгээс хяналт тавих чадварыг эзэмшүүлэхийн тулд хурлын төлөөлөгчид болон иргэдийг энэ сургалтанд хамруулах нь чухал ач холбогдолтой.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулах зохицуулалтыг⁸ бий болгож сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах 20 сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болохоос гадна худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн

⁸ Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 7.1.4 дэх заалт

төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтлан ажиллах болсон юм.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг заавал оролцуулах нөхцөлийг бүрдүүлсэн⁹. Үүний зэрэгцээ хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах замаар захиалагчийн зүгээс явуулж буй худалдан авах үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилт, чанарт хяналт шинжилгээ, аудит хийлгэх ажлыг гүйцэтгүүлж болно. Ийнхүү худалдан авах ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэхэд ИТХ, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангаснаар худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр дүн сайжирч, авлига буурах, төрийн үйлчилгээний чанар дээшлэх, Засгийн газарт итгэх иргэдийн итгэл нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Иймээс аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын зүгээс орон нутгийн төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, орон нутгийн төсөвт хяналт тавих ажилд хурлын төлөөлөгчдийнхөө идэвх санаачилгыг өрнүүлэн ажиллах замаар ИТХ-ын төсөв, санхүүгийн эрх хэмжээгээ үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал юм.

5.4. Орон нутгийн өмчийн талаарх ИТХ-ын эрх хэмжээ

Үндсэн хууль, Иргэний хуульд тодорхойлсон төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

Орон нутгийн өмчийн зүйлс нь нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэнэ.

Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид тухайн орон нутгийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан зам, гүүр, цэцэрлэгт хүрээлэн, гудамжны гэрэлтүүлэг, худаг зэрэг эд хөрөнгө хамаарна.

Орон нутгийн өөрийн өмчид нутгийн өөрийн удирдах байгууллага болон Засаг даргаас хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд тодорхой зориулалтын дагуу өмчлөх эрхийг хэрэгжүүлдэг эд хөрөнгө бусад зүйлс болох барилга байгууламж, газар гэх мэт хамаарна.

Орон нутгийн өмчийг аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчлөлд хамааруулж ойлгож болно.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-д орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг дараах байдлаар тодорхойлсон байна.

- 1) Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;
- 2) ИТХ-ийн хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар

⁹ Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 47.4 дэх заалт

зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;

- 3) Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа төрийн өмчийн хороотой зөвшилцөнө;
- 4) Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.

Мөн орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэх бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлэхээр заасан байна.

Орон нутгийн өмчийн талаарх Засаг даргын бүрэн эрх

Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

Засаг дарга орон нутгийн өмчийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- ИТХ-аас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;
- Орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын Тэргүүлэгчдэд оруулах;
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;
- Орон нутгийн өмчит албан байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах;
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагын дор хувьчлах ажлыг зохион байгуулах.

Аймаг, сумын ИТХ, Засаг даргын шийдвэрээр хөрөнгийг эзэмшигч байгууллагын өмчид бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгана. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг өмчид бүртгэхдээ:

- Ажлын зураг, төсөв
- Гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээ
- Гүйцэтгэлийн зураг, төсөв
- Улсын комисс хүлээн авсан акт
- Ил, далд ажлын акт
- Техникийн тодорхойлолт, хүчин чадлын тодорхойлсон хувийн хэрэг, техникийн паспорт гэрчилгээ, тохирлын гэрчилгээ зэргийг үндэслэл болгоно.

5.5. Орон нутгийн төсөв, өмчийн удирдлага дахь ИТХ-ын Төлөөлөгчийн хүлээх хариуцлага - Ашиг сонирхлоос ангид байх

Нийтийн алба гэдэгт төрийн албыг бүхэлд нь ойлгож болно. *Нийтийн албан тушаалтан* гэдэгт төрийн алба болон татвар төлөгчийн бий болгосон хөрөнгөтэй ямар нэгэн хэмжээгээр харилцдаг этгээдийг хамааруулан ойлгодог. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч нь нийтийн албан тушаалтанд хамаарна.

ИТХ-ын Төлөөлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хуулийг дээдлэн сахих, аливаа асуудалд шударга байр сууринаас хандах, бусдын нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмын баримталж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хэм хэмжээг даган мөрдөж албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг өөрийн буюу хувийн ашиг сонирхлоос ангид байлгах зарчмыг баримтлан ажиллах ёстой.

Төлөөлөгч ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхын тулд дараах асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай. Үүнд:

- Аливаа аж ахуйн нэгж, байгууллагын болон санхүүгийн нөлөөнд автахгүй байх;
- Албаны эрх, үүргээ хувийн зорилгоор ашиглахгүй байж, давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгохгүй байх;
- Бусдад нөлөөлөх оролдлого хийхгүй байх;
- Албан тушаалаа ашиглаж хувьдаа ашиг олохоос зайлсхийх;
- Аливаа үйл ажиллагаанд оролцохдоо өөрийн хамаарал бүхий этгээд болон гэр бүлийн гишүүний хувьд ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл оролцохоос сайн дураар татгалзах бөгөөд энэ тухайгаа ИТХ-ын даргад мэдэгдэх;
- Албаны эд хөрөнгийг хувийн зорилгоор ашиглахгүй байх зэрэг болно.

Нийтийн албан тушаалтны хашиж байгаа ажил алба зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцсэн байх бөгөөд албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг өөрийн буюу хувийн ашиг сонирхлоос ангид байлгах зарчмыг баримтлан ажиллах ёстой. Хувийн сонирхол нь эдийн болон эдийн бус байдаг. Хувийн ашиг сонирхолтой холбоотой өөр нэг зүйл бол хувийн ашиг сонирхол биш атлаа нийтийн сонирхолтой зөрчилдөх ашиг сонирхлын асуудал юм. Өөрөөр хэлбэл, өөрийн сонгуулийн тойрог, улс төрийн намын эрх ашгийн үүднээс нийтийн сонирхлын эсрэг зүйл хийх асуудлууд байдаг. Жишээлбэл, Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч Орон нутгийн өмчит УСНААК-ны захирал нь төсвийн төслийг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх явцад өөрийн компаний цэвэр усны машиныг шинэчлэх шаардлагатай талаар санал оруулж иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн арга хэмжээнд тусгагдсан хөрөнгийг хасуулж цэвэр усны машиныг шинэчлэхэд аймгийн ОНХС-аас 40.0 сая төгрөгийг төсвийн төсөлд тусгуулсан байна. Энэ Төлөөлөгч нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөний зэрэгцээ Төсвийн тухай хуулийн 60.3.6 дахь заалтыг зөрчиж байна.

Улс төрчид өөрийнхөө, эсвэл хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээд, тодорхой бүлгийн төлөө үйлчилж байвал тэдгээрт итгэх иргэдийн итгэл буурдаг.

Сумын ИТХ-ын төлөөлөгч Д нь Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж төсөл сонгон шалгаруулах хуралдаанд оролцсон бөгөөд түүний төрсөн дүүгийн төсөл шалгарч 60.0 сая төгрөгийн зээл авсан байна. Энэ нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 11-р зүйлийг зөрчиж байгаа бөгөөд уг хуулийн 8-р зүйлд заасны дагуу ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчилгүй талаар мэдэгдэл гаргаж, зөрчил үүсэж болзошгүй нөхцөлд татгалзаж эрх бүхий байгууллагад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ДЭЛГЭРҮҮЛЖ СУДЛАХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, 2007
3. Төсвийн тухай Монгол улсын хууль (шинэчилсэн найруулга), 2011
4. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 1996
6. Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2005
7. Татварын ерөнхий хууль, 2019
8. Авлигын эсрэг хууль, 2006
9. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012
10. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль, 2014
12. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 2011
13. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012
14. Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 445-р тогтоол
15. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, Сангийн сайдын 2012 оны 244-р тушаал
16. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам, Сангийн сайдын 2018 оны 228-р тушаал
17. Сум хөгжүүлэх санг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153-р тогтоол
18. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам, Сангийн сайдын 2019 оны 282-р тушаал
19. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29-р тогтоол
20. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, 2017 оны 363-р тушаал
21. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311-р тогтоол
22. Дотоод аудитын дүрэм. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483-р тогтоол
23. Дотоод аудитын хорооны дүрэм. Сангийн сайдын 2013 оны 29-р тушаал
24. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89-р тогтоол
25. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал, Сангийн сайдын 2016 оны 17-р тушаал
26. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, Сангийн сайдын 2013 оны 39-р тушаал
27. Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 24-р тогтоол
28. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230-р тогтоол
29. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам Сангийн сайдын 2019 оны 290-р тушаал
30. Майнбаяр Б. (2011). Дотоод аудит ба дотоод хяналт (COSO), тэдгээрийн ялгаатай талууд. Дэлхийн банк. Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл. Улаанбаатар.
31. ННФ (2014). Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013, Улаанбаатар
32. ННФ (2017). Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2016, Улаанбаатар
33. Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар
34. УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар

